

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Орхон аймаг

2024 оны 12 дугаар сарын 04

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
<b>НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>							
Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж, иргэн бүрийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.							
Зорилт 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.							
1	1.1.1. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажиллах хүний нөөцийг бүрдүүлэх, энэ чиглэлээр чадавхыг нэмэгдүүлнэ. <sup>5</sup>		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	89%	89,5%	Аймгийн Засаг даргын захирамжаар 2023 оны А/84 дүгээр захирамжаар Эрүүл мэндийн газрын бүтэц дэх Нийгмийн эрүүл мэндийн төвд 10 эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг удирдлага, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Тайлант хугацаанд Нийгмийн эрүүл мэндийн төвийн 2 мэргэжилтэн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн мэргэжил дээшлүүлэх институтэд 6 сарын мэргэшүүлэх сургалтад, 7 мэргэжилтэн 34 удаагийн зайн болон танхимын сургалтад хамрагдсан. Сум, өрхийн эрүүл мэндийн төв болон сургууль цэцэрлэг, албан байгууллагын эмч эрүүл ахуйч сувилагчид 59 удаагийн уулзалт ярилцлага, сургалтад давхардсан тоогоор 2315 хүнд зохион байгуулж шинэ мэдээлэл, арга зүйгээр хангасан. Төлөвлөгөөний хэрэгжилт 89,35%-тай байна.	70
2	1.1.2. Хүн амын дунд эрүүл мэндийн суурь судалгааг хийж, түүнд түшиглэсэн эрүүл мэндийг дэмжих бодлого боловсруулан хэрэгжүүлнэ <sup>4</sup>		Суурь судалгааны дүн	1	1-2	Тайлант хугацаанд эрдэм шинжилгээний бага хурлаар 52 илтгэл хэлэлцүүлэгдэж 187 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж олон улсын хэмжээнд 5 илтгэл, улсын хэмжээнд 11 илтгэл хэлэлцүүлэгдсэн. Нийт 5 суурь судалгаа хийгдсэн. Үүнд: - Орхон аймгийн томуу, томуу төст өвчний лабораторид суурилсан тандалтаар эерэг илэрсэн тохиолдлын дархлаажуулалтын байдлын судалгаа - Ундны усны эрүүл ахуйн мэдлэгийн түвшин тогтоох судалгааг 4 багийн 200 хүнийг хамруулж хийж дүгнэхэд мэдлэгийн түвшин 49.3% буюу бага байна. - 14 байгууллагын 847 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан албан хаагчдын бие бялдрын түвшин тогтоох сорилоор А үнэлгээтэй 33.2% , В үнэлгээтэй 30.8 % , С	100

						<p>үнэлгээтэй 26.2%, D үнэлгээтэй 7,4%, F үнэлгээтэй 2,2% байна. Бие бялдрын судалгаанаас D, F үнэлгээтэй 82 эмч эмнэлгийн мэргэжилтэнд эрүүл мэндийн боловсрол олгож, ажлын байрны дасгал хөдөлгөөнийг хэвшүүлэх арга хэмжээ зохион байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Цагаан тоосны нөлөөллийн судалгааг цагаан тоосны нөлөөллийн бүсийн 1866 иргэн болон нөлөөллийн бус бүсийн 193 иргэн нийт 2005 иргэнийг 7 төрлийн үзлэг шинжилгээнд тулгуурлан хийхэд шинжилгээ үзлэгүүдийн дүгнэлтээр цагаан тоосны нөлөөллөөс үүссэн өвчлөл илрээгүй.</li> <li>- Тамхины хэрэглээний судалгааг зорилтот 3 бүлгийн буюу 6-12-р ангийн 12537 сурагч, их дээд сургуулийн 302 оюутан, өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж буй 1160 иргэнийг хамруулан 7 эмч, эмнэлгийн мэргэжилтэн судалгааны ажлыг хийж, танилцуулж, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулсан.</li> </ul>	
3	1.1.3. Эрүүл мэндийн даатгалгүй, зорилтот бүлгийн иргэдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. <sup>3</sup>	100,0 сая	Хэрэгжилтийн хувь	80-90%	82-90%	<p>Тайлант хугацаанд эрсдэлт бүлгийн 705 иргэдийн судалгаа, үйлчлэх хүрээний радиус 40-70 км-т байгааг шинэчлэн тогтоож эрүүл мэндийн байгууллагуудын эмч, резидент нарыг дайчлан 5 удаа эмнэлгийн тусламж үйлчилгээг давхардсан тоогоор эрүүл мэндийн даатгалгүй, малчин, эрсдэлт бүлгийн 2621 хүнд явуулаар хүргэн 7 нэр төрлийн 15 эм, ороох боох материал бүхий 1000 ширхэг малчдын эмийн багцыг түгээсэн байна. Өрхийн эрүүл мэндийн төвүүдээр эрүүл мэндийн даатгалгүй 68 иргэн тусламж үйлчилгээг авсан байна.</p> <p>Аймгийн Засаг даргын 2024 оны А/360 дугаар захирамжаар орон нутгийн 100,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Эрүүл Эрдэнэт хүн” төслийн хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн зорилтот бүлгийн иргэдийг хавдрын эрт илрүүлэг үзлэгт 5000 хүн, 6,17 настай 4100 хүүхэд буюу 93,8%-тай зүрхний цахилгаан бичлэгт, нийгмийн эрүүл мэндийн нөлөөллийн арга хэмжээнд 30000 гаруй иргэний хамруулсан. Шинжилгээгээр өөрчлөлттэй гарсан иргэдийн шинжилгээг лавлагаа шатлалд илгээн, оношийг баталгаажуулсан. Тайлант хугацаанд эрүүл мэндийн даатгалгүй 128 иргэн буюу хамруулахаар төлөвлөсөн зорилтот бүлгийн 64%-ийг үзлэг шинжилгээнд хамруулсан байна.</p>	100

						Эрүүл мэндийн даатгалгүй, зорилтот бүлгийн иргэдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь 95% байна.	
4	1.1.4. Иргэн бүрийг жилд 1 удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажилд бүх шатны төрийн болон аж ахуй нэгж байгууллагын оролцоог сайжруулан, үүрэг хариуцлага, үр дүнг тооцон ажиллана. <sup>1,2</sup>		Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	34.1%	36,9%	Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 738353 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 260204 хийгдэж, нийт үзлэгийн 35.2 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар нэмэгдсэн. Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн хамралт 88,3% болж өмнөх оны мөн үеэс 1,2 %-аар буурсан байна. Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус 168 байгууллагын 5509 ажилтан албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан хамтран ажилласан.	70
5	1.1.5. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг /хөх, умай, чихрийн шижин, цусны даралт ихсэх/ үзлэгийг эрчимжүүлнэ. <sup>3,4</sup>		Эрт илрүүлгийн дундаж хувь	89,5%	89,6%	Тайлант хугацаанд халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн хамралт 88.3% болж өмнөх оны мөн үеэс 1.2 %-аар буурсан байна. Үүнд: - Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 18-с дээш насны нийт 47812 буюу хамрагдвал зохих хүн амын 94.3 хувийг эзэлж, өмнөх оноос (4.3) хувиар өсч үр дүнгийн үзүүлэлтээр 0.7 хувь нь онош батлагдсан. - Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 18-дээш насны нийт 44005 буюу хамрагдвал зохих хүн амын 86.8 хувийг эзэлж, өмнөх оноос (22.9) хувиар буурч, үр дүнгийн үзүүлэлтээр 0.3 хувь онош батлагдсан байна. - Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 3708 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 93.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс (12.4) хувиар буурсан. Пап шинжилгээнд нийт 1662 сорьц хүлээн авсан байна. - Хөхний эрт илрүүлэг үзлэгт 18704 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 90.7 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс (3.3) хувиар өссөн байна. - Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 1330 хүн буюу (76.1) хувь нь хамрагдсан. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, өвчлөлөөс сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн сургагч багш бэлтгэх сургалтад 140 идэвхтэн иргэд, сурагч, сургуулийн өмнөх байгууллага болон ерөнхий боловсролын сургууль, эрүүл мэндийн салбарын 170 эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтад тус тус хамруулсан. Иргэдэд эрүүл мэндийн боловсролыг олгохоор	70

						11 төрлийн постер, зөвлөмжийг 780 иргэнд, цахимд 125 төрлийн постер шторк, зөвлөмжийг байршуулан давхардсан тоогоор 168531 иргэнд хүргэж, 6 удаагийн өдөрлөг зохион байгуулж 14468 хүнийг хамруулж ажилласан.	
6	1.1.6. Улс орон даяар зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт өөрийн харьяа нутаг дэвсгэрийн хүн амыг насны бүлгээр хамруулж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт ажил олгогчид болон салбар дундын хамтын ажиллагааг өрнүүлж хамрагдалтыг 70-аас доошгүй хувьд хүргэнэ. <sup>5</sup>		Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн хувь	41,9%	70%	Тайлант хугацаанд улс орон даяар зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх үзлэгт 63627 буюу нийт хүн амын 59,9 хувь байгаа бөгөөд улсын хэмжээнд 21 аймагтаа хамрагдалтаараа тэргүүлж байна. 0-17 насны 36641 хүүхэд буюу 97,9%, 18-с дээш насанд 26986 буюу 39,2 хувь үзлэгт бүрэн хамрагдсан. Үзлэгээр 55077 хүнд зөвлөгөө өгч, 5010 хүнийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтад авч, 9337 хүнийг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт шилжүүлсэн байна. 87724 өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн ба хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэгээр амны хөндийн өвчлөл, насанд хүрэгчдийн үзлэгээр хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл тэргүүлж байна. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэхээр Аймгийн Засаг даргын 2024 оны А/155 дугаар захирамж, Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/27 дугаар тушаалаар ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан үр дүнг тооцон ажилласан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна. Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/150 тоот тушаалын хүрээнд нүүдлийн эмнэлгийг орон нутагт ажиллуулан урьдчилан сэргийлэх, үзлэг, шинжилгээ, оношилгоог идэвхжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны А/298 захирамжаар 2.6 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэн Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 19 эмч эмнэлгийн мэргэжилтний баг 618 иргэнийг насны багцын дагуу урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулан үзлэг 0,6 хувиар нэмэгдсэн. Эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоог идэвхжүүлэхээр Бүсийн оношилгоо эмчилгээний төв дурангийн нэгдсэн кабинетыг нээн үзлэгийн хүлээгдлийг бууруулсан. Тайлант хугацаанд ходоодны дурангийн шинжилгээнд 4822 хүн орсноос улаан хоолойн 19, ходоодны хавдар 41 илрүүлж, эрт үедээ оношлогдсон ходоод, улаан хоолойн 38 хавдрыг салст хуулах хагалгаагаар эмчлэн эрүүлжүүлсэн байна.	70
7	1.1.7. Хэрэгжилтийн хугацаа дуусаж буй дараах		Арга хэмжээний	88.1%	88,5%	Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилт дунджаар 88,42 хувьтай байна.	80

	<p>арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллана.<sup>5</sup></p> <ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл идэвхтэй амьдрал;</li> <li>- Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд;</li> <li>- Хавдрын эсрэг;</li> <li>- Харшлаас сэргийлэх;</li> <li>- Эрүүл чийрэг эр хүн;</li> <li>- Элэг бүтэн Монгол;</li> <li>- Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх;</li> <li>- Орчны эрүүл мэнд</li> </ul>		<p>төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж хувь</p>			<p>2024 онд нийгмийн эрүүл мэндийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд нийт 281.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгуулан хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр орон нутгийн төсвөөс 154 иргэнд 84.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн нь хавдрын шинээр батлагдсан тохиолдлын 80,2 хувийг эзэлж байна.</li> <li>- Томуу, томуу төст өвчний урьдчилан сэргийлэх болон дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл, эмч, эмнэлгийн мэргэжилтний илүү цагийн хөлсийг шийдвэрлэсэн.</li> <li>- Аймгийн Засаг даргын 2024 оны А/360 дугаар захирамжаар орон нутгийн 100,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Эрүүл Эрдэнэт хүн” төслийн хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн зорилтот бүлгийн иргэдийг хавдрын эрт илрүүлэг үзлэгт 5000 хүн, 6,17 настай 4100 хүүхэд буюу 93,8%-тай зүрхний цахилгаан бичлэгт, нийгмийн эрүүл мэндийн нөлөөллийн арга хэмжээнд 30000 гаруй иргэний хамруулсан байна.</li> </ul> <p>Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 738353 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 260204 хийгдэж, нийт үзлэгийн 35.2 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар нэмэгдсэн байна. Нийт 235 удаагийн сургалт сурталчилгаанд давхардсан тоогоор 35899 иргэнийг хамруулж, 40 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизэд, 5 удаагийн мэдээллийг FM радиогоор хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн.</p>	
8	<p>1.1.8. Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд” арга хэмжээг зохион байгуулж, амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх ялангуяа алслагдсан бүс нутагт амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэн амны хөндийн үзлэг,</p>		<p>Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь</p>	-	80%	<p>Тайлант хугацаанд нийт 90 байгууллагын 16000 хүнд сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж 1200 хүүхдэд урьдчилан сэргийлэх фторт түрхлэг түрхсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Шүд эрүүл бол бие эрүүл” аяны хүрээнд 39 цэцэрлэгийн эмч арга зүйчийг сургалтад хамруулан тэднээр дамжуулан 27186 багш, эмч, арга зүйч хүүхдийг сургалтад хамрууллаа.</li> <li>- “Зөвийг дадал болгоё” аяны хүрээнд шүд угаах дадлыг хэвшүүлэх болзолт уралдаан зарлаж, 19, 12, 24, 26 дугаар цэцэрлэгийн 1200 хүүхдийг хамруулан 1 ангийг шалгаруулан өргөмжлөл үнэ бүхий зүйлээр урамшуулсан.</li> <li>- Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран 16 байгууллагын албан хаагчдад хөдөлмөрийн аюулгүй</li> </ul>	100

	оношилгоо, эмчилгээний явуулын баг ажиллуулна.. <sup>5</sup>					<p>байдал эрүүл ахуйн сарын хүрээнд ажлын байранд “Шүд угаах цаг гаргая” аяныг өрнүүлж 70 сургагч багш бэлтгэн 860 албан хаагчид онол дадлага хосолсон сургалтыг зохион байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Оюутны эрүүл дэмжих сарын аяны хүрээнд Эрдэнэт цогцолбор дээд сургууль, Орхон Политехникийн коллежийн 700 гаруй оюутанд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан.</li> <li>- Цахимаар 54 мэдээллийг 25400 хүнд түгээж ажилласан байна</li> </ul> <p>Боловсролын газартай хамтран сургалт сурталчилгааг зохион байгуулсны дүнд ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллага 7 хоногийн 1 өдөр шүд угаах цаг гарган сургалт дадлага хийж хэвшиж байна. Хүүхдийн 37 цэцэрлэг “Шүд угаах цаг”-ийг хэвшүүлж, хүүхэд шүдээ зөв угаах дадал хэвшилтэй болж байна. "Эрүүл шүд" арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 82,1 хувьтай байна.</p>	
Зорилт 2. Хог хаягдлын менежментийг сайжруулж, орчны сөрөөг нөлөөллийг бууруулах эрүүл мэндийн цогц арга хэмжээг бусад салбарын дэмжлэгтэй хэрэгжүүлэх							
9	1.2.1. Эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлын менежментийг сайжруулах, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах <sup>4</sup>		Үйл ажиллагааны тайлан	85%	86%	<p>Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын тээвэрлэлт, устгалын үйл ажиллагааг бүх шатны 52 эрүүл мэндийн байгууллага “Ногоон ариусал” ХХК-тай гэрээгээр 2024 оны эхний 8 сард гүйцэтгүүлж ажилласан. Байгаль орчны хяналтын байцаагчийн “Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг түр түдгэлзүүлэн зогсоох тухай” 01/25-01/59/09 актаар Ногоон ариусал” ХХК-ийн үйл ажиллагааг түр зогсоосон тул БОЭТ нь эрүүл мэндийн аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, боловсруулах устгах үйл ажиллагааг 2024 оны 9 сараас хариуцан ажилласан. Тайлант хугацаанд халдвартай хог хаягдал 43023,85 кг, хурц үзүүртэй, ирмэгтэй хог хаягдал 11221 кг, эмгэг хог хаягдал 771.89 кг, эсэд хортой хог хаягдал 222,6 кг, химийн хог хаягдал 103,12 кг устгасан байна.</p> <p>Хог хаягдлын менежментийг сайжруулах 1 удаагийн хяналтыг хувийн хэвшлийн болон анхан шатны бүх эрүүл мэндийн байгууллагуудад хийж, зөвлөмжөөр хангаж ажилласан. Орон нутгийн 15 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэгээр эмнэлгийн аюултай хог хаягдлыг булшлах нүх болон</p>	90

						тусгаарлах хашааг барьсан. "Ногоон ариусгал" ХХК, Хот тохижуулах газартай хамтран 26 эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал хариуцсан ажилтан, халдвар сэргийлэлтийн ажилтныг чадавхжуулах сургалтад 51 хүнийг хамруулсан. Эрүүл мэндийн яам ХӨСҮТ-өөс зохион байгуулсан "Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын ажилтан" бэлтгэх болон сургагч багш бэлтгэх сургалтад 5 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Нээлттэй хаалганы өдөрлөгүүдээр иргэдэд хогоо хэрхэн ангилан ялгах мэдээлэл зөвлөгөөг өгч сурталчлан, хог хаягдлын олон талт эрүүл мэндийн боловсролыг салбар бүрд хүртээмжтэй хэлбэрээр хүргэхээр эрүүл мэндийн сургагч багшийг бэлтгэх сургалтад 100 иргэнийг хамруулсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны санхүүжилтээр аймгийн хэмжээнд хог хаягдлын нэгдсэн цэгт аюултай хог хаягдал хадгалах зориулалтын байр барих ажил 80%-тай явагдаж байна. Эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны тайлан 85,9%-тай байна.	
10	1.2.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд эрүүл мэндийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх		Тарьсан модны тоо	1000	800	Монгол улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, Орхон аймгийн Засаг даргын 2022 оны А/688 дугаар захирамж, Орхон аймгийн "Ногоон Эрдэнэт" хөтөлбөрийн хүрээнд нийт эрүүл мэндийн байгууллага нэгдэж тайлант хугацаанд эрүүл мэндийн байгууллага нэгдэж тайлант хугацаанд нийт 1512 мод тарьснаас агч мод 270, бургас 352, монос 60, шинэс 210, шар хуас 370, борт гол 250 ширхгийг тус тус тарьсан байна.	100
11	1.2.3. Байгууллагын орчны 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, өвлийн улиралд цас, мөсийг тухай бүрт нь арилган, халтиргаа гулгаа үүсэхээс урьдчилан сэргийлж, эрүүл аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллана.		Тайлан мэдээ	-	Тухай бүр	Байгууллагын орчны 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээг 3 удаа хийж, өвлийн улиралд цас, мөсийг тухай бүрт нь арилган, халтиргаа гулгаа үүсэхээс урьдчилан сэргийлж, эрүүл аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллаж тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлж, сурталчилж ажилласан.	100

Зорилт 3. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдал, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг бэхжүүлж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, салбар хоорондын оролцоо, халдварт өвчнийг хамтын ажиллагаанд тулгуурлан бууруулах.

12	<p>1.3.1. Халдварт өвчний тохиолдол бүрт тандалт судалгаа хийх, халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр хэрэгжиж буй тушаал шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах, эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээ авах чиглэлээр холбогдох салбарын байгууллагуудтай хамтран ажиллана<sup>4</sup></p>		Хэрэгжилтийн хувь	90,7%	92%	<p>Тайлант хугацаанд 707 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 67.2 промилл буюу өмнөх оны мөн үеэс 24.35 промиллоор буурсан байна. Нийт халдварт өвчний 36.5%-ийг амьсгалын замын халдварт өвчин, 19.2%-ийг бэлгийн замаар дамжих халдварт өвчин, 35.4%-ийг мөөгөнцрийн халдвар, 8.2%-ийг гэдэсний халдвар, 0.7%-ийг бусад халдварт өвчин тус тус эзэлж байна.</p> <p>Амьсгалын замын халдварт өвчний 49.2%/127/ салхин цэцэг эзэлж, өмнөх оны мөн үеэс 25.3 промиллоор буурсан байна. Сүрьеэгийн өвчлөл 98 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 9,3 промилл байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 3,7 промиллоор, бэлгийн замаар дамжих халдварын 136 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 12,9 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 0,3 промиллоор тус тус өссөн байна.</p> <p>Орон нутгийн санхүүжилтээр сүрьеэгийн идэвхтэй илрүүлэг, үзлэг зохион байгуулж нийт 575 хүн хамрагдахаас 543/94,3%/ хамрагдаж, сүрьеэтэй байж болзошгүй 179/33%/ тохиолдлоос холбогдох шинжилгээ авч, 26 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс 115 сорил, 64 цэрний шинжилгээ хийж цэрний шинжилгээгээр батлагдсан тохиолдол байхгүй, сорил эерэг 26 илрүүлж, эмчилгээнд хамруулсан. Монголын тархвар, халдвар судлагч эмч нарын нийгэмлэгтэй хамтран эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд, үсчин гоо сайханч нийт 50 хүнийг халдварын хяналт сэргийлэлтийн сургалтад хамруулсан. Дархлаажуулалтын хамралт 99,8%-тай байна. Хоолны хордлогын 500 гаруй хүнийг хамарсан 1 удаагийн дэгдэлт, зоонозын халдварт өвчний 2 удаагийн сэжигтэй, 1 батлагдсан тохиолдлын хариу арга хэмжээг ХӨСҮТ, ЗӨСҮТ, болон салбарын байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажилласан. Улсын хэмжээнд улаанбурхан өвчний тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Улсын Онцгой комиссын 2 удаагийн албан даалгаврын хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд ханган ажилласан. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх сургалтад нийт эмч. эмнэлгийн мэргэжилтний 37%-ийг хамруулсан байна. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх</p>	100
----	--	--	-------------------	-------	-----	--	-----



						арга хэмжээ /2022-2025 он/-г хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт 92,5%-тай байна.	
13	1.3.2. Зоонозын шалтгаант болон дамжуулагчаар дамжих өвчний тандалтын тогтолцоог өргөжүүлэх, хариу арга хэмжээний чадавхыг сайжруулах, салбарын байгууллагуудтай хамтран ажиллана <sup>4</sup>		Хэрэгжилтийн хувь	84,1%	85%	<p>Тайлант хугацаанд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Нэг эрүүл мэнд” салбар зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж, 4 чиглэлээр 15 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж ажилласан ба хэрэгжилт 87,1%-тай байна.</li> <li>- Галзуу чононд хазуулсан 1 тохиолдлын голомтын хариу арга хэмжээг ЗӨСҮТ болон Сэлэнгэ аймгийн Зоонозын өвчин судлалын төвтэй хамтран зохион байгуулж ажилласан. Сүүлийн 5 жилд галзуугийн вакцин хамрагдсан иргэдийн бүрэн тунгийн хамралтад хийсэн судалгаагаар вакцин хамрагдсан иргэдийн 58% бүрэн тунд хамрагдаагүй дутуу орхисон, эрсдэлд өртсөн эх уурхайн 80,6% эзэнтэй нохойд уруулсан, шархны хэлбэрийн хувьд 91,6% хөнгөн, хүйсийн хувьд 59,3% эрэгтэй байгаа бол 5-15 нас 28,6%, 20-44 нас 29,3%, 45-64 нас 28,6%-ийг тус тус эзэлж байна.</li> <li>- Аймгийн хэмжээнд ажиллаж буй 30 малын эмчийг бруцеллэз өвчний урьдчилан сэргийлэх үзлэгт, 19 хүнийг шинжилгээнд хамруулснаас бруцеллэзын халдварын 4 тохиолдол илэрч эмчилгээнд хамруулсан.</li> <li>- Хачигт халдвараас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх 11 арга хэмжээ бүхий төлөвлөгөө батлуулан ажилласан ба хэрэгжилт 90%-тай байна. Хачигт халдварын 5 тохиолдлын шинжилгээг ЗӨСҮТ-д хүргүүлж, 3 тохиолдол үгүйсгэгдсэн.</li> <li>- “Тарваган тахал өвчний хяналт, сэргийлэлтийн арга хэмжээг эрчимжүүлэх тухай” Эрүүл мэндийн сайдын 01 албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор батлагдсан Эрүүл мэндийн газрын даргын А/55 дугаар тушаалыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг 95,6%-тай ханган ажилласан.</li> <li>- Хүний боомын сэжигтэй тохиолдол 1 бүртгэгдэж, голомтын хариу арга хэмжээг Мал эмнэлгийн газартай хамтран зохион байгуулж, сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн голомтод хязгаарлалтын дэглэм тогтоон холбогдох шинжилгээг авч ажилласан.</li> </ul> <p>Зоонозын шалтгаант болон дамжуулагчаар дамжих өвчний тандалтын тогтолцоог өргөжүүлэх, хариу арга хэмжээний чадавхыг сайжруулах үйл ажиллагааны хэрэгжилт 90%-тай байна.</p>	100

Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Орчин үеийн оношилгоо эмчилгээний дэвшилтэт технологийг өргөжүүлэх замаар орон нутагтаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлж эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

Зорилт 1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах							
14	2.1.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн дэвшилтэт технологийн ашиглалтыг сайжруулах, иргэдэд хүртээмжтэй болгох, үр дүнг тооцож ажиллана.		Ашиглалтын хувь	90,6%	90,8%	<p>Эрүүл мэндийн байгууллагуудад хийгдсэн удирдамж бүхий хяналтаар стандартын дагуу тоног төхөөрөмжийн хангалт дунджаар 92,1%, ашиглалт ашиглалт дунджаар 91,6%-тай байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тоног төхөөрөмжийн хангалт дунджаар 96%, ашиглалт 87,5%</li> <li>- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 95,5%, ашиглалт 93%</li> <li>- Эрдэнэт медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт 92%, ашиглалт 90%</li> <li>- Эрдэнэт клиник, сувилалд 85%, ашиглалт 96%-тай байна.</li> </ul> <p>Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Харвалт шигдээсийн төвд ангиографийн аппаратын рентген хоолойг орон нутгийн 400,0 сая төгрөгийн санхүүжилтээр сольж ашиглалтад оруулснаар тайлант хугацаанд 62 хүнийг оношилгоонд хамруулсан.</p> <p>Эрдэнэт Медикал төрөлжсөн эмнэлэгт тархины судасны доплерийн төрөлжсөн мэргэшлийн сургалтад эмчийг хамруулан тайлант хугацаанд 74 хүнд оношилгоо хийгдсэн байна.</p> <p>БОЭТ-ийн амбулатори болон төрөх тасагт 500,0 сая төгрөгийн эмэгтэйчүүдийн суурин болон зөөврийн эхо аппарат, 129,6 сая төгрөгийн чих хамар хоолойн үзлэг болон төвөнхийн харалтын иж бүрэн дуран, 150,0 сая төгрөгийн БОЭТ-ийн ургийн гажгийг эрт оношлох ЭХО тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдэн тусламж үйлчилгээнд ашигласан.</p>	100
15	2.1.2. Нотолгоонд суурилсан эмнэлзүйн тусламж үйлчилгээг нэвтрүүлэх, олон улсын түвшний “Up to date” платформыг ашиглалтыг сайжруулна.		“Up to date” платформыг ашиглаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	70%	70.5%	<p>Нотолгоонд суурилсан анагаах ухаан, эмнэлзүйн заавар ашиглалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд UpToDate программын хэрэглээг өргөжүүлэх сургалтад 30 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, анагаахын англи хэлийг сайжруулах анхан шатны сургалтад 10 эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Эрдэнэт сувилал, клиник нь “UpToDate-ийн хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр эмч нарын дунд мэргэжил, үр чадварын уралдааныг зохион байгуулж 5 багийн 35 эмч оролцсон. Эрүүл мэндийн сайдын 2023, 2024 онд батлагдсан 12 эмнэлзүйн зааврын хэрэгжилтийг нэмэгдүүлэх зорилгоор</p>	100

						эмнэлзүйн сургагч багш бэлтгэх сургалтад 3 эмчийг хамруулж, 9 удаагийн эмчилгээ, оношилгооны арга зүйн танхимын сургалтыг 3 чиглэлээр 258 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан зохион байгуулсан. Тайлант хугацаанд нийт эмч нарын 72,5% нь тус платформд бүртгэл үүсгэж ашиглаж, өмнөх онтой харьцуулахад 2,5 хувиар нэмэгдсэн байна.	
16	2.1.3. Улс, орон нутгийн түвшинд туршлага судлах, тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн шинэ төрөл, технологийг бүс нутгийн хэмжээнд өргөжүүлэх, сурталчилна.		Нэвтрүүлсэн шинэ төрлийн технологи, эмчилгээ, үйлчилгээний тоо	3	3	Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төвд дараах дэвшилтэт технологийг нэвтрүүлэн бүс нутгийн хүн амд тусламж үйлчилгээг үзүүлж, лавлагаа шатлалд явах урсгалыг 25- 30,0%-аар бууруулсан байна. Үүнд: - Харвалт шигдээсийн төвд судсан дотуурх оношилгоо эмчилгээг 141 хүнд хийснээс 43,6%-д нь стент тавьсан байна - Эрэгтэйчүүдийн жишиг кабинетад 34 хүнд дурангаар шээлгүүрт стент тавих, чулуу авах 2 үе шаттай хагалгааг хийсэн. - Орон нутгийн 210.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар зүрхэн дотор цахилгаан сэдэл өгөх аппарат, зүрхний холтер монитор, чих хамар хоолойн үзлэгийн дуран, нүдний мэс заслын микроскоп, нярайн сонсгол шалгах аппарат, өвдөгний үений хөдөлгөөн нөхөн сэргээх аппарат зэрэг шинэ технологийг нэвтрүүлж оношилгооны чадавхыг нэмэгдүүлсэн. - Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг GEhealth care компанийн өндөр хүчин чадал бүхий 1,5 тесла Signa creator MRI аппарат болон revolution maxima select компьютер томографийн аппаратуудыг шинээр суурилуулан эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй үнээр нийт 258 хүнд оношилгоо хийгдсэн. - Баян-Өндөр мед эмнэлэг нь хиймэл оюун ухаанд суурилсан умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг оношилгооны "CerviCare AI" системийг нэвтрүүлэн 1007 хүнд үзлэг, шинжилгээ хийж, үтрээний шүүрлийн шинжилгээг 927 хүнд, RMC эмнэлэгтэй хамтарсан үргүйдлийн оношилгооны кабинетаар 26 хүнд оношилгоо хийж, лавлагаа шатлалд 5 хүнийг илгээсэн байна. - НҮБ-ын хүүхдийн сангийн санхүүжилтээр АШУҮИС-ийн "Нярайн скринингийн салбар төв"-ийг БОЭТ-ийн нярайн тасагт байгуулж, төрсөн нярай бүрт 5 төрлийн бодисын	100

						<p>солилцооны эмгэг илрүүлэх нярайн скрининг оношилгоо хийгдэж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- НҮБ-ын Хүүхдийн Сан, аймгийн ЗДТГ-тай хамтран стрептококкын скрининг үзлэгт 5400 гаруй хүүхдийг хамруулсан.</li> <li>- Орбис ОУБ-ын санхүүжилтээр ЭХЭМҮТ-тэй хамтран хүүхдийн нүдний хавдрыг илрүүлэх улаан рефлексийн аргыг нэвтрүүлэн хүүхэд, нярайн 9 эмчийг 2 өдрийн чадавхжуулах сургалтад хамруулж, багажаар 100% хангасан. Нүдний угийн улаан рефлексийн оношилгоог 305 нярайд хийхэд эмгэг илрээгүй байна.</li> </ul> <p>Тайлант хугацаанд сурфактант эмчилгээг амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 18 нярайд хийж, 72.2 хувийн үр дүн өгсөн байна.</p>	
17	2.1.4. Иргэдийн дунд авлагагүй донорын эгнээг өргөжүүлж, аюулгүй цус цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлнэ. <sup>1,2,3,5</sup>	Орон нутгийн төсөв 8.0 сая	Цус цусан бүтээгдэхүүний нөөц	100%	100%	<p>Аймгийн Засаг даргын 2024 оны А/229 дугаар захирамжаар 8,0 сая төгрөгийг шийдвэрлэж, “Тогтмол хугацаанд цус, сийвэнгээ бэлэглэе” уриан дор сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх, цусны аюулгүй байдлыг хангах, донор хадгалах идэвх санаачилгыг өрнүүлэх аяныг зохион байгуулсан.</p> <p>Суурин цус цуглуулалтаар 562 донороос 562 нэгж цус, шинэ 140 донороос 140 нэгж цус цуглуулсан. Цусны салбар төвд бүртгэлтэй 562 донорт цусны АВО, Резус бүлэг, Келл бүлэг, цус, цусан бүтээгдэхүүнээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээг хийж 100% баталгаажуулсан ба резус эерэг 560, сөрөг 2 донор бүртгэгдсэн. Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх тусламж үйлчилгээний бэлэн байдлыг үнэлэх чиглэлээр 67 эмч эмнэлгийн мэргэжилтнийг сургалтад хамруулсан. Тайлант хугацаанд 1152 нэгж цус цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэснээс 908 нэгж цус цусан бүтээгдэхүүнийг зарцуулсан байна. Цус цусан бүтээгдэхүүн сэлбэлттэй холбоотой урвал хүндрэл 2 бүртгэгдсэн. Тайлант хугацаанд цус цусан бүтээгдэхүүний хангалт 100%-тай байна..</p>	100
18	2.1.5. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, тусламж үйлчилгээний чиглэл бүрээр алба, багуудыг чадавхжуулах, мэргэжил арга зүйгээр хангах, хяналт тавина. <sup>5</sup>		Алба, багийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	90%	<p>Сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв, хувийн хэвшлийн ортой 13 клиникт чанарын баг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг, Эрдэнэт сувилалд нийт чанарын 5 алба ажилласан. Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, “Чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө”-ний хэрэгжилт,</p>	100

						<p>Эмчилгээ чанарын албад, багийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт 5 удаа, чадавхжуулах чиглэлээр сургалт мэдээлэл 6 удаа хийж, зөвлөмжөөр хангаж ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд чанарын албаны хурал 98, дотоод хяналт 114, ижил мэргэжилтний үзлэг 32 чиглэлээр 376 удаа хийж, тусламж үйлчилгээтэй холбоотой 273 тохиолдол бүртгэн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр төвийн болон дотоодын 28 сургалт, 6 хэлэлцүүлэг зохион байгуулж, давхардсан тоогоор 424 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан байна.</p> <p>Эрүүл мэндийн байгууллагууд <a href="http://eburtgel.moh.gov.mn">http://eburtgel.moh.gov.mn</a> цахим программд тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдлыг бүртгүүлж хэвшсэн ба Эрүүл мэндийн газраас программын бүртгэл, хариу арга хэмжээний хэрэгжилтийн байдалд тогтмол хяналт тавьж ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд бүртгэгдсэн 273 тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдлоос эмнэлзүйн шалтгаан 43,6%, эмнэлзүйн бус шалтгаан 46,2%, бусад 9,2% бүртгэгдэж, хариу арга хэмжээг 85%-д авч ажилласан байна. Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлж ажиллах чиглэлийг эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагуудад өгч, 2 удаагийн сургалтад 249 хүнийг хамруулж, 199 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, удирдлагад мэдээлэл хүргэн, хэрэгжилтэд 2 удаа хяналт хийж зөвлөмж өгч ажилласан. Эрүүл мэндийн байгууллагуудын 92% нь үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгчийг танин тодруулах журмыг хэрэгжүүлж хэвшсэн бөгөөд хэрэгжилт 91.5%-тай байна. Эрүүл мэндийн байгууллагуудын 95% нь үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж, унаж халтирахаас сэргийлсэн, санамж байршуулсан ба ажилбар хийхээс өмнө үйлчлүүлэгчид танилцуулж, зөвшөөрөл авч хэвшсэн байна.</p> <p>Эмчилгээ чанарын албад, багийн чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилт дунджаар 93,1%-тай үнэлэгдсэн.</p>		
Зорилт 2. Анхан шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг нэг цэгээс тусламж үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх								
19	2.2.1. Өрхийн эрүүл мэндийн гүйцэтгэлийн	эрүүл төвтэй гэрээ		Өрхийн эрүүл мэндийн төвийн	88.3%	90%	Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй Засаг Дарга, Эрүүл мэндийн газрын дарга хамтран ажиллах гэрээ байгуулж, тайлант хугацаанд 3 төлөвлөгөөт хяналт, 6 дэмжлэгт хяналт,	100

	байгуулж, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлд тогтмол хяналт тавин ажиллана. <sup>4,5</sup>		гүйцэтгэлийн гэрээний дундаж хувь			5 зөвлөмж, 2 чиглэл хүргүүлж гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. Эрүүл мэндийн сайдын 2024 оны “Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журмыг батлах тухай” А/122 тоот тушаалын дагуу өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээний гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний баг, журам, шалгуур үзүүлэлтийг шинэчлэн баталсан. Эмчилгээ чанарын хяналтын болон эрүүл ахуйн улсын байцаагчийн төлөвлөгөөт хяналтаар 8 өрхийн эрүүл мэндийн төв “бага” эрсдэлтэй дүгнэгдсэн. Анхны Оч болон Нийцэл, Мөнхсүндрэл өрхийн эрүүл мэндийн төвүүд ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны анхан шатны баталгаажуулалтад хамрагдсан. Гэрээний гүйцэтгэлийн хэрэгжилтийг жилд 2 удаа тухайн жилийн 7-р сарын дотор, дараа жилийн 1-р сарын дотор үнэлэхээр тусгагдсан бөгөөд тайлант хугацаанд 2024 оны эхний хагас жилийн гэрээний гүйцэтгэлийг Үнэлгээний баг ажлын байранд болон цахимаар 2 удаа хийж, эрүүл мэндийн даатгалын өвөрмөц үзүүлэлт, үндсэн үзүүлэлт, нийтлэг шалгуур, дээд шатны байгууллагын үнэлгээ, нэмэлт, онцгой шалгуур үзүүлэлт гэсэн 5 үзүүлэлтээр үнэлсэн. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гүйцэтгэлийн гэрээний дундаж 92,7% болж, өмнөх оны мөн үеэс 5,4%-аар нэмэгдсэн байна.	
20	2.2.2. Жаргалант сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.		Гэрээний хэрэгжилтийн хувь	92,7%	92,8%	Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Жаргалант сумын Засаг дарга, Эрүүл мэндийн газрын даргаар батлуулан хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Тайлант хугацаанд: <ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн төвд нийт 9092 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 36.3% байна.</li> <li>- Гэрийн идэвхтэй эргэлт 27.7% байгаа нь өмнөх оны мөн үеэс 13.5%-аар нэмэгдсэн, гэрийн дуудлага 753 байна.</li> <li>- Жирэмсний хяналтад шинээр 33 эмэгтэй орж, эрт үеийн хяналтад 97.0% хамрагдсан, 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан хувь 75.8 хувь болсон нь өмнөх оны мөн үеэс 13.3%-аар нэмэгдсэн байна.</li> <li>- Нүүдлийн эмнэлгээр ирсэн лавлагаа шатлалын эмч нарын эрт илрүүлэг үзлэгт зорилтот бүлгийн 84 иргэнийг хамруулж, өвчлөл илэрсэн иргэдийг дээд шатлалын эмнэлэг рүү шилжүүлсэн.</li> </ul>	100

						<ul style="list-style-type: none"> <li>- Сүрьеэгийн эрсдэлт бүлгийн үзлэгийг Эрүүл мэндийн газрын даргын А/23 дугаар тушаалын дагуу БОЭТ-ийн сүрьеэгийн эмч нартай хамтран 40 хүнийг хамруулсан.</li> <li>- Заавал хийх дархлаажуулалтын хамрагдалтын хувь 100% байна.</li> <li>- Нийт 426 хүн хэвтэн эмчлүүлж, дундаж ор хоног 7 байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 93,1%-тай байна.</li> </ul>	
21	2.2.3. Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулан стандарт чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчин бүрдүүлнэ. <sup>3</sup>	Улсын төсөв 3,2 тэрбум  Орон нутгийн төсөв 60.0	Стандартын шаардлага хангасан орчин бүрдүүлсэн эрүүл мэндийн төв	88,9%	100%	<p>Тайлант хугацаанд барилга байгууламжийн чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тайлант хугацаанд Эрүүл мэндийн сайдын багцад 1.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Цагаан чулуут багт өрхийн эрүүл мэндийн төвийг шинээр барих барилга тусгагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны газраас тендер зарлагдана.</li> <li>- Орон нутгийн төсвийн 253.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Анхны Оч өрхийн эрүүл мэндийн төвийн дээврийн болон дотор засвар, Баян-Өндөр сумын ИТХ-ын тогтоолоор Мөнхийн Гэгээ өрхийн эрүүл мэндийн төвд 24.8 сая төгрөгийн дээврийн завсар, Жаргалант сумын ИТХ-ын тогтоолоор Жаргалант сумын эрүүл мэндийн төвд 356.0 сая төгрөгийн их засвар хийгдсэн.</li> </ul> <p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмжийг сайжруулах чиглэлээр 276.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс орон нутгийн төсөв 163.7 сая (59,2%), төсөл хөтөлбөр 112.7 сая (40,8%) төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Орон нутгийн 60.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3 өрхийн эрүүл мэндийн төвийг мобайл технологиор, 17.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Анхны-Оч, Мөнхсүндрэл өрхийн эрүүл мэндийн төвийг нярайн шарлагын аппаратаар, 48.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Анхны-Оч өрхийн эрүүл мэндийн төвийг цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппарат, нярайн шарлагын аппаратаар, 9.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мэндцэцэн өрхийн эрүүл мэндийн төвийг шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр, Жаргалант сумын эрүүл мэндийн төвд 29,0 сая төгрөгийн шарлагын аппарат болон тавилга багаж хэрэгслээр тус тус хангасан</li> <li>- Азийн Хөгжлийн банкны МОН-9218 төслийн хүрээнд 13.7 сая төгрөгийн өртөг бүхий 6 нэр төрлийн 54 ширхэг тоног</li> </ul>	100

						<p>төхөөрөмжийг сум, өрхийн дархлаажуулалтын 9 нэгжид, олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд нүдний улаан рефлекс шалгах Arclite багажийг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 15 ширхгийг тус тус хуваарилсан. Мөн Дезерет олон улсын байгууллагаас Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 99,0 сая төгрөгийн нярайн шарлагын аппарат болон бусад техник хэрэгслээр хангасан.</p> <p>Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 96% болж өмнөх оноос 0,4%-аар нэмэгдсэн ба 100% стандартын шаардлага хангасан орчин бүрдүүлсэн байна.</p>	
Зорилт 3. Эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах, тусламж, үйлчилгээнд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах							
22	2.3.1. Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэх, жирэмсний хяналтын чанарыг сайжруулан, жирэмсэн үеийн ХДХВ, тэмбүү, гепатитын В,С вирусийн илрүүлэг шинжилгээний хамралт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн, эмчилгээ, эмчилгээний дараах хяналт, хавьтлын илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний байдалд хяналт тавин ажиллана. <sup>5</sup>		Жирэмсний эрт хяналтын хувь	98,3%	98,3%	<p>Аймгийн хэмжээнд жирэмсний тусламж үйлчилгээг сум, 8 өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нөхөн үржихүйн нэг цэгийн үйлчилгээний жирэмсний өртөмтгий бүлгийн хяналтын кабинет, төрөх тасаг үзүүлж ажилласан. Тайлант хугацаанд анхан шатлалын Эрүүл мэндийн байгууллагуудын 92% нь эх баригчийг орон тоогоор дагнан ажиллуулснаар жирэмсний эрсдэлийг илрүүлэх үнэлгээ, жирэмсний нэрийн хяналт сайжирч, лавлагаа шатлалд жирэмсний өртөмтгий бүлгийн кабинетын эмчийн орон тоог 5 болгон нэмэгдүүлснээр жирэмсэн үеийн хүндрэл эрсдэлийг эрт илрүүлэх, мэдээлэл солилцох, эмч эмнэлгийн мэргэжилтний ур чадвар нэмэгдэж, жирэмсний хяналт сайжирч 99.4%, өмнөх оноос 1.1 хувиар өссөн байна. Хяналтад байгаа нийт жирэмсний 87,6% нь жирэмсний хэвийн явцтай гэж үнэлэгдэн анхан шатлалд, 12,4% нь жирэмсний өндөр эрсдэлийн улмаас лавлагаа шатлалын эмнэлэгт нарийн мэргэжлийн эмчийн хяналтад хянагдсан. Жирэмсний хяналтад байгаа жирэмсэн эмэгтэйчүүдийн 99.6 хувь цусны шинжилгээнд хамрагдсанаас 33 буюу 2.1 хувь нь цус багадалттай байна. Шинээр хяналтад хамрагдсан 1563 жирэмсэн эмэгтэйн гепатитын В,С вирусийн илрүүлэг шинжилгээ, ХДХВ, тэмбүүгийн хурдавчилсан сорилд 99.6 хамруулж, трихомониаз 28 буюу 1.8 хувь нь эерэг, тэмбүү 9 буюу 0.6 хувь нь эерэг, заг хүйтэн 3 буюу 0.2 хувь эерэг тус тус гарч, оношийг баталгаажуулан, хавьтагчийн хамт эмчилгээнд 100% хамруулсан байна. Тайлант хугацаанд гепатитын В,С вирусийн халдвартай 20 жирэмсэн эхийг хяналтад авч 17 нярайг 12 цагийн дотор вакцинд хамруулан, 3 нярайд В вирусийн эсрэг иммуноглобулин (HBIG) хийж</p>	90,9



						халдвар дамжихаас сэргийлж ажилласан бөгөөд төрөлхийн тэмбүүгийн тохиолдол бүртгэгдээгүй байна.	
23	2.3.2. Суурь өвчтэй хүүхдүүдийг улирлын чанартай гэр сувилалд хамруулан эрүүлжүүлэн чийрэгжүүлнэ. <sup>3</sup>	ОНТ 30.0	Суурь өвчтэй хүүхдийн эрүүлжсэн хувь	88%	89%	Тайлант хугацаанд суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувиллыг гэрээгээр гүйцэтгүүлэхээр орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийг шийдвэрлэснээр Бүжинлхам хувийн хэвшлийн хүүхдийн клиник сульдаа, уураг илчлэгийн дутагдал, цус багадалт зэрэг суурь эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй 100 хүүхдийг нар ус агаараар чийрэгжүүлэх зуны сувилалд хамруулсан. Эрүүл мэндийн газраас дэмжлэгт хяналтыг тус зуны сувиллын үйл ажиллагаанд 1 удаа хийж, эрүүл ахуй халдвар хамгаалал, эмчилгээ, бүртгэл судалгаа, зорилтот бүлгийн хүүхдүүдийн хамралтад мэргэжил аргагүйн зөвлөмж өгч хяналт тавьж ажилласан. Суурь өвчтэй хүүхдийн эрүүлжсэн хувь 89,5%-тай байна.	100
24	2.3.3. Хүүхэд, өсвөр үе болон нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. <sup>2,4</sup>		Өсвөр үе болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн үзлэгт хамруулсан хувь	22%	22,5%	Тайлант хугацаанд эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр 9 албан тоот хүргүүлж, 2 удаагийн хяналт хийн зөвлөмж хүргүүлсэн. - Томуу, томуу төст өвчний тархалт идэвхжилийн түвшинд хүрч, хүүхдийн тасгийн ачаалал 2 дахин нэмэгдсэн тул 100 хүртэлх орыг нэмэлтээр дэлгэж, анхан шатлалд гэрийн эргэлтийг идэвхжүүлэн томуугийн салбар дундын ажлын хэсгийн 3 удаагийн хурлын шийдвэрийн хэрэгжилтийг 90,5% ханган ажилласан. - Эрүүл мэндийн газрын дэргэдэх Магадлан хэлэлцэх зөвлөл 3 удаа хуралдаж, амьгүй болон гэрийн төрөлт, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн нийт 16 тохиолдолд үзүүлсэн тусламж үйлчилгээг дүгнэн хэлэлцэж, нөлөөлсөн хожимдол, сургамж, зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. - Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан сургалтаар давхардсан тоогоор нийт 554 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан. - НҮБ-ын Хүүхдийн Сан, аймгийн ЗДТГ-тай хамтран хэрэгжүүлж байгаа стрептококкын скрининг үзлэгт 5400 гаруй хүүхдийг хамруулсан. - Хүчирхийлэлд өртсөн 5, жирэмсэлсэн 2 өсвөр насны охидын мэдээллийг Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газар БОЭТ-тэй солилцож, эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн.	70

						<ul style="list-style-type: none"> <li>- Эрт илрүүлэг үзлэгт нийт 0-5 насны хүүхдийн 88.3%, 6-17 насны хүүхдийн 80.7% нь хамрагдсан байна.</li> <li>- Жирэмсний эрт үеийн хяналт 99.4 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1.1 хувиар нэмэгдсэн.</li> <li>- Нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 9,8 промилл, өнгөрсөн оны мөн үеэс 1,6 промиллоор, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 10,3 промилл, өмнөх оны мөн үеэс 0,7 промиллоор нэмэгдсэн.</li> <li>- Аймгийн хэмжээнд нөхөн үржихүйн тусламж үйлчилгээг БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн 9 төв, хувийн хэвшлийн нөхөн үржихүйн 6 клиник үзүүлэн ажилласан.</li> <li>- Тайлант хугацаанд нөхөн үржихүйн насны 24369 эмэгтэй байгаа гэр бүл төлөвлөлтийн арга хэрэгсэлд 15760 буюу 65,4%-ийг, урьдчилан сэргийлэх үзлэгт 61,2%-ийг хамруулан 84,7%-ийг эрүүлжүүлсэн байна.</li> </ul>	
25	2.3.4. Жирэмсэн эмэгтэйн амь насанд ноцтой хүндрэл гарч зайлшгүй тээвэрлэх шаардлага үүссэн тохиолдолд онгоц болон бусад тээврийн хэрэгслийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган дэмжлэг үзүүлнэ.		Дэмжлэг үзүүлсэн тоо	2	Тохиолдол бүрт	Тайлант хугацаанд жирэмсэн эхийн ноцтой хүндрэлийн 2 тохиолдлыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн зардлаар тээвэрлэн хүргэж, дээрх 2 эхийн амь нас аврагдсан байна.	100
Зорилт 4. Уламжлалт, сэргээн засах, хөнгөвчлөх, сувилахуйн тусламж үйлчилгээг цогц, нэгдмэл байдлаар хөгжүүлж, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх							
26	2.4.1. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээг нэгдмэл байдлаар үзүүлэх, бусад тусламж үйлчилгээтэй хослуулан төрөлжүүлэн үзүүлнэ. <sup>4</sup>		Үйл ажиллагааны тайлан, хэрэгжилтийн хувь	90%	90,5%	<p>Уламжлалт анагаах ухааны чиглэлээр 90 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж, хүний нөөцийн хангалт 85 хувьтай байна. Тайлант нийт уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг 88137 иргэнд, сэргээн засах эмчилгээг 66648 иргэнд үзүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,9%-аар нэмэгдсэн байна.</p> <p>Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд сэргээн засах эмчилгээнд БНХАУ-ын Фангао брэндийн нүд, толгой, хүзүү, нурууны массажны аппарат, чихний лаа эмчилгээг нэмэгдүүлснээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,1%-аар өссөн байна.</p> <p>“Эмч” хөтөлбөрийн хүрээнд Монголын нэгдмэл анагаах ухааны нийгэмлэгтэй хамтарсан “Бид дорнын анагаах ухааны эмч” ажил мэргэжлийн уралдаанд нийт 6 багийн 18 уламжлалт анагаах ухааны их эмч, бага эмч, сувилагч нар</p>	100

						<p>оролцож, түрүүлсэн багийн бүрэлдэхүүн БНСУ-ын Дэгү хотын эмнэлэгт туршлага судалсан. Эмч мэргэжилтнийг чадавхжуулах чиглэлээр дотоодын 4 сургалт, уламжлалт анагаах ухааны технологийн хүрээлэнтэй хамтран уламжлалт анагаах ухааны эмийн жор судлалаар 2 кредит багц цагийн, Тэжээхүй ухаан төрийн бус байгууллагатай хамтран 2 багц цагийн сургалтыг тус тус зохион байгуулж давхардсан тоогоор 111 эмч, сувилагч хамрагдсан. Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн уламжлалт анагаах ухааны их эмч нарыг Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Эрдэнэт сувиллын Уламжлалтын тасаг болон сэргээн засах эмчилгээний тасгуудад ажлын байран дээр дадлагажих үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан.</p> <p>Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээний үйл ажиллагааны хэрэгжилт 98%-тай байна.</p>	
27	2.4.2. Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах, нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээг өргөжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. <sup>4</sup>		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	95%	97%	<p>Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн 160 гаруй байгууллагад 5 алба, 51 тасагт 842 сувилагч, тусгай мэргэжилтэн ажиллаж байгаагаас 36.8%-ийг мэргэжлийн зэрэгтэй байна.</li> <li>- Тайлант хугацаанд 251071 иргэнд сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлж, цахим видео хичээл 92 түгээж, хандалт 10620, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад 32720 иргэн хамруулсан.</li> <li>- Сувилахуйн тусламж үйлчилгээтэй холбоотой 61 тохиолдол бүртгэгдэж, үүнээс 93,4% нь 1А тохиолдол байна.</li> <li>- Чадавхжуулах сургалтад 683 буюу нийт сувилагч, тусгай мэргэжилтний 80,4% хамрагдаж, 8 удаагийн тохиолдлын хэлэлцүүлэг зохион байгуулсан.</li> <li>- “Шинэ сувилагчийн сургалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх загвар аймгаар сонгогдон Сувилахуйн сургуулийг 2024 онд төгссөн 13 шинэ сувилагчийг 3 сарын хугацааны сургалтад хамруулж, Эрүүл мэндийн яаманд тайланг амжилттай хэлэлцүүлсэн.</li> <li>- Тус хугацаанд удирдамжийн дагуу дэмжлэгт хяналт хийж, 2 зөвлөмж хүргүүлсэн.</li> <li>- Мэдлэг, ур чадварын түвшин тогтоох шалгалтад 361 сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдаж, 80% буюу хангалттай үнэлэгдсэн.</li> </ul>	100

						<ul style="list-style-type: none"> <li>- Сувилагч нарын дунд анх удаа ур чадварын уралдаан зохион байгуулж, 10 багийн 50 сувилагч мэдлэг ур чадвараа сорин өрсөлдсөн.</li> <li>- “Сайн үйлсийн аян”-ны хүрээнд 15 сувилагчид 10.0 сая төгрөгийн хандив тусламж үзүүлсэн.</li> <li>- Аймгийн хэмжээнд тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр 40 туслах сувилагч ажиллаж байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ажиллаж буй 12 туслах сувилагчийн цалинд 147,9 сая төгрөгийг шийдвэрлэсэн.</li> <li>- Төрөлжсөн мэргэшлийн сургалтад 20, гадаад улсад 4 сувилагч, тусгай мэргэжилтэн мэргэжил дээшлүүлэхээр суралцаж байна.</li> <li>- Сувилахуйн сургуультай хамтран судалгааны арга зүйн сургалтад 55 сувилагчийг хамруулж, Эрдэм шинжилгээний хуралд 54 судлаачийн 15 илтгэл хэлэлцүүлэн шалгарсан 5 илтгэлийг “Олон улсын сувилагчдын судалгааны эмхэтгэл ном”-д хэвлүүлэн, улсад 11 илтгэлийг амжилттай хэлэлцүүлсэн.</li> </ul>	
28	2.4.3. Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. <sup>4</sup>		Хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	116	200	<p>Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны үйл ажиллагаандаа 3 зорилтын хүрээнд 49 үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжилт 100%-тай байна. Эрүүл мэндийн байгууллагад олон мэргэжлийн баг бүрдсэнээр тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн. Эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалтыг 2 удаа зохион байгуулж, анхан шат болон лавлагаа шатлалын 48 эмч, сувилагч хамрагдсан. Хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд хэрэгжиж буй тушаал, шийдвэр, стандартын хэрэгжилтэд 1 удаа дэмжлэгт хяналт хийж, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан. Аймгийн хэмжээнд сум, ерхийн эрүүл мэндийн төвийн хяналтад 4,5-р бүлгийн 2531 иргэн байна. Үүнээс 1385 иргэн буюу 54,7% нь гэрийн тусламж үйлчилгээнд, 231 иргэнд хөнгөвчлөх тусламж үйлчилгээг уламжлалт эмчилгээтэй хавсран хийгдсэнээр үр дүн гарсан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хөнгөвчлөхийн тасаг нь тайлант хугацаанд бүтцийн өөрчлөлт хийгдэж Хавдар, хөнгөвчлөх эмчилгээний тасаг болж 15 ор, хими эмчилгээний 4 ор, нийт 19 ортой тусламж үйлчилгээ үзүүлж байна.</p> <p>Хүнд, хүндэвтэр 398 үйлчлүүлэгчид сувилгааны түүх хөтөлж, сувилагч нарын дунд сувилгааны түүх хөтлөлтийг сайжруулах</p>	100

						хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тайлант хугацаанд 23 сэдвийн хүрээнд давхардсан тоогоор 841 үйлчлүүлэгч, 150 асран хамгаалагчийг сургалтад хамруулсан. Тайлант хугацаанд хөнгөвчлөх тусламж үйлчилгээг давхардсан тоогоор 541 үйлчлүүлэгчид үзүүлсэн байна.	
Зорилт 5. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн чадавхыг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээний тасралтгүй шуурхай байдлыг ханган хамтран ажиллах							
29	2.5.1. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээ байгуулж дүгнэнэ.		Гэрээний хэрэгжилтийн дундаж хувь	95,3%	95,5%	Хувийн хэвшлийн 1 нэгдсэн эмнэлэг, 11 ор бүхий клиникүүдтэй аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газар хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллалаа. Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд 106965 үзлэг хийсэн нь аймгийн хэмжээнд хийгдсэн нийт үзлэгийн 14.5%-ийг, 17595 иргэнийг хэвтүүлэн эмчилсэн нь нийт эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн 52.3%-ийг эзэлж, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ачааллыг хуваалцсан байна. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын клиникийн бүтэц үйл ажиллагаа MNS6673:2017 стандартын хэрэгжилтэд 2 удаа үнэлгээ хийж, зөвлөмжөөр хангасан ба хэрэгжилт дунджаар 89% байна. - “Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандарт”-аар хяналт хийхэд дунджаар 90,8%, өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 0,5%-аар сайжирсан байна. - “Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт түгээлтэд тавих шаардлага MNS5530:2014 стандарт”-ын хэрэгжилт дунджаар 95,1% байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 1,2%-аар сайжирсан байна. Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан гэрээний хэрэгжилт дунджаар 91,5%, стандартын хэрэгжилтийн дундаж 89,5%-тай байна.	70
30	2.5.2. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын оношилгооны чадавхыг сайжруулах, тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.		Оношилгооны чадавх	90%	90,5%	Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд оношилгооны чадавхыг сайжруулж, оношилгооны чадавх 91%-тай байна. Тухайлбал: - Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг, Тайхар, Ачит, Эрхэст-Оргил ор бүхий клиникүүд нь лаборатори болон оношилгооны дэвшилтэт технологийг нэвтрүүлж, үзүүлж буй тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлсэн.	100

						<ul style="list-style-type: none"> <li>- Дурангийн тусламж үйлчилгээ үзүүлдэг Их сүүмэн клиник SUMSNUG брэндийн өндөр хүчин чадалтай ЭХО аппаратыг авч оношилгооны хүчин чадлыг нэмэгдүүлсэн.</li> <li>- Нейрон клиникт 24 цагийн нойрны бичлэг, уналт таталтыг тогтоох бичлэгийг бүс нутгийн хэмжээнд үзүүлж байна.</li> <li>- Тайхар эмнэлэг нь өндөр хүчин чадалтай ЭХО аппаратыг бүхий зүрхний доплер оношилгоог хийхээр оношилгооны чадавхыг нэмэгдүүлсэн байна.</li> </ul> <p>Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний нэр төрөл 3 -аар нэмэгдсэн байна</p>	
31	2.5.3. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлнэ. <sup>3</sup>		Гэрээт үйлчилгээний тоо	2	2	<p>Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хувийн хэвшлийн төрөлжсөн эмнэлэг 1, хүүхдийн 4 клиник томуу томуу төст өвчний үеийн тусламж үйлчилгээний ачаалал, хүлээгдлийг бууруулах чиглэлээр гэрээний дагуу уртасгасан цагийн зохицуулалт хийж хамтран ажиллалаа.</li> <li>- Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувиллыг гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг жил бүр зохион байгуулж ирсэн ба 2024 онд орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийг шийдвэрлэснээр Бүжинлхам хувийн хэвшлийн хүүхдийн клиниктэй гэрээ байгуулан ажиллаж сульдаа, уураг илчлэгийн дутагдал, цус багадалт зэрэг суурь эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй 100 хүүхдийг нар ус агаараар чийрэгжүүлэх зуны сувилалд хамруулсан.</li> <li>- Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулахад 6 хувийн хэвшлийн нөхөн үржихүйн клиниктэй гэрээ байгуулан 16-49 насны 942 эмэгтэйг үзлэгт хамруулан 38.5 хувийг бүрэн эмчлэн эрүүлжүүлэн, лавлагаа шатлалд 374 эмэгтэйг илгээсэн байна.</li> <li>- Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд Эрүүл Эрдэнэт хүн төслөөр зохион байгуулагдсан “Шүдний олимпиад”-д гэрээний дагуу шүдний 15 клиник хамтран ажилласан байна.</li> </ul>	100
32	2.5.4. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах,		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	100%	Тусгай зөвшөөрөл олгох комиссын 12 удаагийн хурлаар нийт 89 асуудлыг хэлэлцэж, сунгалт хийлгэх 39 байгууллагын материалыг хүлээн авч үйл ажиллагааг 5 жилээр сунгаж, 10 байгууллагыг түдгэлзүүлж, 5 байгууллагад хаягийн	100

	түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагуудад хяналт хийнэ.					шилжилтийн зөвшөөрлийг олгосон. Шинээр нээх 9 төслийг хүлээн авч, 1 дотор, 1 сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлэх клиникт тусгай зөвшөөрлийг олгон, 12 байгууллагын зөвшөөрлийг хүчингүй болгосон. Сунгалт хийлгэх байгууллагуудад салбарын хяналтын байцаагч нарын дүгнэлт, ажлын албанаас 8 удаа хяналтын дүгнэлтийг тус тус комиссын хурлаар хэлэлцүүлсэн. Ажлын албанаас эрх зүйн баримт бичгийн шинэчлэлт, халдвар сэргийлэлт, эмийн чанар аюулгүй байдал, сувилахуйн чиглэлээр 45 клиникийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалт зохион байгуулсан. Орон тооны бус 2 шинжээчийг шинээр нээх 5 төсөл болон 3 ажлын байранд ажиллуулж, үнэлгээг комиссын хуралд оруулж шийдвэрлүүлсэн. License.mn сайтад нийт 163 байгууллагын мэдээллийг шивж, туршилтаар сунгуулах 2 байгууллагын мэдээллийг оруулсан. ЭМХТ-д тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, цахим программын сургалтад хамрагдсан. Хууль эрх зүйн хэлтэст 2023 оны сунгасан, шинээр олгосон, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон байгууллагуудын дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж хүргүүлсэн. Орон тооны бус шинжээчийн сонгон шалгаруулалтыг ЭМГ-ын цахим хуудас, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлаж 1 шинжээчийн материалыг сонгон шалгаруулсан. Ажлын албанаас түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон нийт 17 байгууллагад тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага хангах албан бичгийг хүргүүлж, 1 эмийн сан, 1 клиникт ирүүлсэн иргэний 2 гомдлыг шийдвэрлэж ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 100% байна.	
Зорилт 6. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, эмнэлзүй, эм зүйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх, нянгийн тэсвэржилтийг судалж, антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хяналтыг сайжруулна. <sup>1,2</sup>							
33	2.6.1. ЭХНБ-ын MNS 5530:2014, Эмийн сангийн MNS5260:2015 стандартын хэрэгжилтийг хангуулах, хянанана. <sup>3</sup>		Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангуудын стандартын хэрэгжилт	95%	98%	Аймгийн хэмжээнд нийтийн үйлчилгээтэй 77 эмийн сан, 8 эм ханган нийлүүлэх байгууллага иргэдэд үйлчлэн ажилласан. 2024 онд эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоогүй бөгөөд 1 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг цуцлан, 4 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг 1 сарын хугацаатай түдгэлзүүлсэн байна. Эмийн зохистой хэрэглээний 10 хоногийн хүрээнд 40 эмч, эм зүйчийг сургалтад хамруулж, иргэдэд хандсан сургалт сурталчилгааг эрчимжүүлэн ажилласан. Сэтгэцэд нөлөөт эмийн 3938 ширхэг жорыг 11 байгууллагад, мансууруулах эмийн жорыг 8 байгууллагад	98,2

						1257 ширхгийг тус тус дугаарлан олгосон. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх эмийн сангуудыг ЭМГ-ын даргын 2024 оны А/25 тоот тушаалаар шинэчлэн баталсан. Эм ханган нийлүүлэх байгууллага болон эмийн сангуудын стандартын хэрэгжилт дунджаар 96.2 хувь байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 1.1 хувиар нэмэгдсэн байна. Үүнд: - “Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандарт”-аар хяналт хийхэд 94.9%-тай үнэлгээтэй гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 1.1%-аар сайжирсан байна. - Эм ханган нийлүүлэх байгууллагын стандартын шаардлага 97.5%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 0.5%-аар сайжирсан байна.	
34	2.6.2. Эмнэлзүйн эм зүйн тусламж үйлчилгээг нэмэгдүүлнэ. <sup>3,4</sup>		Хэрэгжилтийн хувь	82,1	82,5%	Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 132 эм зүйч, 116 эм найруулагч ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эм зүйч 4 хувь, эм найруулагч 0,87 хувиар тус тус нэмэгдсэн байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 6 клиник эм зүйч, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад 11 клиник эм зүйч ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.7%-аар нэмэгдсэн байна. Эмнэл зүйн эм зүйн тусламж үйлчилгээнд хяналт хийхэд нийт өвчтөний 49.6-58.2 хувьд тарилгыг хийж, 41.8-50.4 хувьд уухаар эмийг өгсөн байгаа нь өмнөх онтой харьцуулахад эмийг тарилгын хэлбэрээр хэрэглэх явдал 2.2 хувиар буурч, ууж хэрэглэх эмийн хувь 6.8-9.0 хувиар нэмэгдсэн, зонхилон тохиолдох эмгэгийн оношилгоо, эмчилгээний удирдамжийн хэрэгжилт 87.2 хувь болж 3.1 хувиар нэмэгдсэн, эмийн зохистой хэрэглээ алдагдал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.5 хувиар буурсан байна. Эмнэл зүйн тусламж үйлчилгээний хэрэгжилт 2024 онд 85.2 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 2.1%-аар нэмэгдсэн байна.	85.2%
35	2.6.3. Нянгийн тэсвэржилтийг судалж, антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх <sup>2</sup> , антибиотекийг жоргүй олгох үйл ажиллагааг таслан зогсоох, энэ		Хяналтын дүн, хийгдсэн судалгааны тоо	1	1	Эрүүл мэндийн байгууллагуудын ахлах сувилагч, сувилагч, эм зүйч 38 хүнд эм зүйн мөрдөгдөж буй хууль тогтоомж, жор бичилтийн стандарттай холбоотой мэдээлэл, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажилласан. Эрүүл мэндийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөгт эмийн зохистой хэрэглээний талаар сурталчилгааг 700 гаруй хүнд хийсэн. Эмийн сангуудад жорын маягт, жор бичилтийн MNS5376:2016 стандартын мэдээллийг 77 эмийн санд хүргүүлсэн. Нийт	<u>100</u>



	чиглэлээр байнгын хяналт тавина.					эмийн сангуудад Жор бичилт, жорын маягт MNS5376:2016 стандартын хэрэгжилтэд хяналт хийхэд 87,5%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,1%-аар сайжирсан байна. Аймгийн хэмжээнд Аксис программ ашиглаж эмийн нэр, тун хэмжээ, хэрэглэх аргыг нь бичиж эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй мэдээлэл солилцон ажилласан. Аксис программд шинжилгээ хийлгэсэн болон мэдрэг чанар заавал оруулах тохиргоо бүхий байгаа нь нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг хянах боломжийг бүрдүүлсэн. 2024 оны байдлаар макролидын бүлгийн антибиотикт 90-100% мэдрэг байхад цифалоспорины бүлгийн антибиотик 40-50% мэдрэг гарсан нь макролидын бүлгийн антибиотикүүд нь эмчилгээнд илүү үр дүнтэй байна.	
36	2.6.4. Мансууруулах, сэтгэц нөлөөт эмийн хяналтыг сайжруулна. <sup>2</sup>		Хяналтын дүн, хэрэгжилтийн хувь	97,3%	97,5%	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчилдэг 12 эмийн сан, 2 эм ханган нийлүүлэх байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эмийн сангуудаар 2 удаагийн хяналт хийж, хяналтаар хэрэгжилт дунджаар 97,5%-тай гарсан байна. Мансууруулах эмийн жорыг 6 байгууллагад 1287 ширхэг, сэтгэцэд нөлөөт эмийн жорыг 12 байгууллагуудад 4236 ширхэг тус тус шифрлэж олгон хяналт тавьж ажилласан.	100
37	2.6.5. Эм эмнэлгийн хэрэгслийг оновчтой тооцон худалдан авах ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, ерөнхий гэрээгээр худалдан авч буй эм, эмнэлгийн хэрэгслийг өөр эх сурвалжаас авахгүй байх арга хэмжээг хэрэгжүүлнэ. <sup>5</sup>		Хэрэгжилтийн хувь	100%	100%	Tender.gov.mn сайтаар ажил үйлчилгээ, бараа худалдан авч ажилласан. Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 61 багцад 5,5 тэрбум төгрөгийн төсөв бүхий худалдан авах ажиллагаа зохион байгуулсан бөгөөд 1 багцын худалдан авах ажиллагаа амжилтгүй болж, 2 багцад үнийн санал авсан, 58 багцад 29 компани шалгаран гэрээ байгуулан сар тутам тогтмол, тасалдалгүй нийлүүлж ажилласан. Тайлант хугацаанд 5.28 тэрбум төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл бусад шаардлагатай барааг авч ажилласан. Мөн Ерөнхий гэрээгээр 20 компанитай 85 нэрийн эм, 6 нэрийн эмнэлгийн хэрэгслийг нийт төсөвт өртөг 1,5 тэрбум төгрөг байгаа бөгөөд одоогийн байдлаар 1,072 саяд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл авч ажилласан. Эрдэнэт медиал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг мөн төрийн өмчид шилжсэнээр худалдан авах ажиллагаа зохион байгуулж 42 багцын эм, эмнэлгийн хэрэгсэл, тодосгогч бодисын авах нийт төсөвт өртөг 2.1 тэрбум төгрөг, үүнээс 22 багцад тендер шалгаран гэрээ байгуулан ажилласан. Мөн ерөнхий гэрээгээр 15 компанитай 45 нэрийн эм, 6 нэрийн	100

						эмнэлгийн хэрэгслийн 233 сая төгрөгийн гэрээ байгуулснаар 218 сая төгрөгийн буюу 93,5%-тай худалдан авалт хийсэн байна. Нийт худалдан авалтын гэрээ байгуулсан компаниудын нийлүүлэлт 92,0%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,2%-аар гэрээний хэрэгжилт сайжирсан байна. Тус цахим сайтад тендерийн худалдан авах үйл ажиллагааны бүх мэдээллийг хуульд заасан хугацааны дагуу байршуулж ил тод байдлыг ханган ажилласан.	
Стратегийн зорилго 3. Эрүүл мэндийн ажилтны урт чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, харилцаа, хандлагыг дээшлүүлэн, нийгмийн баталгааг сайжруулна. <sup>1, 2, 5</sup>							
Зорилт 1. Эмнэлгийн мэргэжилтний нийгмийн асуудлыг дэмжих, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах.							
38	3.1.1. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудлыг дэмжих “Эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. <sup>3,4</sup>	ОНТ 130.0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	96.5%	96.8%	Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын 2024 оны А/86-р захирамжаар “Эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 130.0 сая төгрөг, аймгийн ИТХ-ын 2024 оны 18/05 тогтоолоор 20.0 сая төгрөг нэмэлтээр тус тус батлагдсан. Хөтөлбөрийн хүрээнд: - Бид дорнын анагаах ухааны их эмч”, “Миний мэргэжил-Миний бахархал-Би эмч”, “Миний мэргэжил-Миний бахархал-Би сувилагч” сэдвээр ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулж 104 эмч эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. - Эрүүл мэндийн байгууллагуудын 6 эмнэлгийн мэргэжилтэн БНСУ, 8 өрхийн эрүүл мэндийн төвийн дарга ӨМӨЗО-ны Хөх хотын эрүүл мэндийн байгууллагаас туршлага судалсан. - 11 удаагийн сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөнд давхардсан тоогоор 1530 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. - Дэлхийн эмч нарын болон олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан зохион байгуулсан онол практикийн бага хуралд 106 судлаач оролцсон. - Эрдэнэт хотын “Илгээлтийн эзэд” эрүүл мэндийн салбарын 100 ахмадын уулзалтыг зохион байгуулсан. - Эрүүл мэндийн салбарын 36 ажилтанд 36,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. - Эрүүл мэндийн байгууллагуудын 70 ажилтныг умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг, 24 ажилтныг бүдүүн гэдэсний дуранд хамруулсан. Тайлант хугацаанд төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь 14 байгаа нь өмнөх оноос 0,9%-аар нэмэгдсэн ба нийгмийн дэмжлэгт хамрагдсан эрүүл	100

						мэндийн ажилтны эзлэх хувь 27.8% болж өнгөрсөн оны мөн үеэс 3.4%-аар өссөн. “Эмч” хөтөлбөрийн хэрэгжилт 98,7%-тай байна.	
39	3.1.2. Үр бүтээлтэй ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудад олгох урамшууллын багцыг хэрэгжүүлэн ажиллана.		Шагнал урамшуулалд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний хувь	10,5%	10,5%	Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын дагуу эрүүл мэндийн салбарын төрийн захиргааны албан хаагчдын цалин 12%, Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолоор орон нутагт ажилласны нэмэгдэл 20%, 2022 оны 491 дүгээр тогтоолоор төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тус тус олгосон. Эрүүл мэндийн байгууллага бүр албан хаагчдын үр дүнг сар бүр үнэлж, урамшууллыг улирал тутам олгож ажилласан. Аймгийн Засаг даргын А/06 дугаар захирамжийн дагуу Эрүүл мэндийн газрын 5 мэргэжилтэнд төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвийг журмын дагуу нэмэгдүүлсэн. “Бид Дорнын анагаах ухааны их эмч”, “Миний мэргэжил-Миний бахархал-Би эмч”, “Миний мэргэжил-Миний бахархал-Би сувилагч” сэдвээр ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулж шалгарсан 6 эмнэлгийн мэргэжилтэн БНСУ-ын эрүүл мэндийн байгууллагад туршлага судлах эрхийн бичгээр шагнагдсан. Эрдэнэт сувилал нь ажил мэргэжлээрээ тэргүүлэн ажилласан 7 сувилагчийг үндсэн цалингийн 20%-аар шагнаж урамшуулсан. Мөн тус байгууллага нь орон сууц худалдан авсан 3 ажилтанд тус бүр 13.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. “Сайн үйлсийн аян”-ны хүрээнд 15 сувилагчид 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тайлант хугацаанд төрийн одон медалиар 2, ЭМЯ-ны шагналаар 50, орон нутгийн шагналаар 53 эмч, эмнэлгийн мэргэжилтэн тус тус шагнагдсан байна. Тэргүүний эрүүл мэндийн ажилтан”-аар 1 эмчийг шалгаруулсан. Шагнал урамшуулалд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны 16,3% хамрагдаж, өмнөх онтой харьцуулахад 5.8 хувиар өссөн байна.	100
Зорилт 2. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн төлөвлөлт, хөгжлийг хангах							
40	3.2.1. Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн төлөвлөлтийг батлуулах, хэрэгжүүлнэ.		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	89,8%	89,9%	Эрүүл мэндийн салбарын 2022-2026 оны хүний нөөцийн төлөвлөлтийг 2 чиглэлээр төлөвлөж, хангалт 91%-тай байна. 2024 оны байдлаар эрүүл мэндийн салбарт 2073 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд үүнээс 452 их эмч, 507 сувилагч ажиллаж байна. 2023-2024 онд төрийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад 82 эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн суралцсанаас улсын төсвийн	100

						санхүүжилтээр 46 эмч, эмнэлгийн мэргэжилтэн буюу 3,2% нь суралцсан. Төлөвлөлтийн дагуу нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмчийн эзлэх хувь 92% болж өмнөх оноос 5 хувиар нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарт нийт 12 эмч, эмнэлгийн мэргэжилтэн Улаанбаатар хот болон бусад орон нутгаас шилжин ирж ажиллаж байна.	
41	3.2.2. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн /нэн шаардлагатай мэргэжлээр бэлтгэх/ сургалтад хамруулна. <sup>4</sup>		Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь	13,1%	13,2%	2023-2024 онд улсын төсвийн болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад 82 эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн суралцсанаас улсын төсвийн санхүүжилтээр 46 эмч, эмнэлгийн мэргэжилтэн буюу 3,2% нь суралцсан. ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа "Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах" төслийн хүрээнд 2023-2024 онд буюу 6 дахь жилийн сургалтад "Яаралтай тусламжийн сувилахуй"-аар 2 сувилагч элсэн суралцсан. Тус төслийн хүрээнд "Шинэ сувилагчийн сургалтын хөтөлбөр", "Эмнэл зүйн шатлал"-ийн хөтөлбөрийг Орхон аймагт улсын хэмжээнд анх удаа эхлүүлэн 12 шинэ сувилагчийг хөтөлбөрийн дагуу ажлын байранд нь дадлагажуулсан. Нэн шаардлагатай 12 нарийн мэргэшлээр 13 эмч суралцсан. Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь 14% байна	100
42	3.2.3. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байрны, зайн сургалтад хамруулна.		Сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь	74,9%	75%	Тайлант хугацаанд 1412 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажлын байрны болон алсын зайн сургалтад хамрагдсан нь нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний 91%-ийг эзэлж байна.	100
43	3.2.4. Эмнэлгийн мэргэжилтнийг дээд шатлалын эмнэлэгт ажлын байранд дадлагажуулан сургах, лавлагаа шатлалын эмнэлгийн мэргэжилтнийг БОЭТ, төв эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон анхан шатлалд сэлгэн ажиллуулах арга хэмжээг авна. <sup>4</sup>		Ажлын байранд дадлагажуулсан эмнэлгийн мэргэжилтний тоо	108	110	Тайлант хугацаанд 163 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг лавлагаа шатлалд болон анхан шатлалд сэлгэн ажиллуулсан байна. Үүнд: - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хүүхдийн тасагт томуу томуу төст өвчний дэгдэлттэй холбоотой өрхийн эрүүл мэндийн төвийн давхардсан тоогоор нийт 126 эмчийг ажлын байранд сэлгэн ажиллуулсан. - Уламжлалт анагаах ухааны хувийн хэвшлийн эмнэлгийн 9 эмчийг Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон Эрдэнэт сувиллын цогцолборын сэргээн засах тасагт сэлгэн ажиллуулсан. - БОЭТ, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ачааллыг буруулах зорилгоор үндсэн мэргэшлийн сургалтад суралцаж байгаа	100

						28 резидент эмчийг орон нутагт өрхийн эрүүл мэндийн төвүүдэд сэлгэн ажиллуулсан.	
Стратегийн зорилго 4. Эрүүл мэндийн салбарт чиглэсэн санхүүгийн урсгалын тогтвортой байдлыг хангах, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллах							
Зорилт 1. Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчин бүрдүүлэх							
44	4.1.1. БОЭТ-ийг орчин үеийн тоног төхөөрөмжөөр үе шаттай хангаж, иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломж бүрдүүлнэ. <sup>3,4</sup>	Орон нутгийн төсөв 500.0	Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	95,2%	95,5%	Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь стандартын дагуу нэн шаардлагатай болон шаардлагатай 898 ширхэг багаж тоног төхөөрөмжтэй бөгөөд үүнээс эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн дэвшилтэт технологийн багаж тоног төхөөрөмжийн эзлэх хувь 20,1%-тай байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 95.6 хувьтай байна. БОЭТ-ийн амбулатори болон төрөх тасагт 500,0 сая төгрөгийн эмэгтэйчүүдийн суурин болон зөөврийн эхо аппарат, 129,6 сая төгрөгийн чих хамар хоолойн үзлэг болон төвөнхийн харалтын иж бүрэн дуран, 150,0 сая төгрөгийн БОЭТ-ийн ургийн гажгийг эрт оношлох ЭХО тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдэн ашиглагдаж байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 540,3.0 сая төгрөгийн түргэн тусламжийн бүрэн тоноглогдсон автомашинаар хангагдсан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 96 хувьтай, өмнөх оноос 0,5%-аар нэмэгдсэн байна.	100
45	4.1.2. БОЭТ-ийн амбулаторийн өргөтгөлийн зураг төсөв боловсруулна. <sup>3</sup>		Боловсруулагдсан өргөтгөлийн зураг төсөв	-	100%	Орон нутгийн хөрөнгөөр амбулаторийн өргөтгөлийн зургийг зуруулж “Вилла Проект” ХХК зураг, төсөв боловсруулан Барилга захиалагчийн албанд хүлээлгэн өгсөн. Уг зураг төсөвтэй барилгын төсвийг 2025 оны улсын төсөвт тусгах саналыг хүргүүлсэн.	100
46	4.1.3. БОЭТ-ийн Мэс заслын нэгдсэн тасаг, гэмтлийн тасгийн засварыг хийж, стандарт чанарын шаардлага хангасан эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ. <sup>3</sup>	Орон нутгийн төсөв 838,5	Засвар хийгдсэн байна.	-	100%	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар БОЭТ-ийн Мэс заслын нэгдсэн тасагт 533,3 сая төгрөг, Гэмтлийн тасгийн их засварт 305,2 сая төгрөг тус тус батлагдаж нийт <b>838,5</b> сая төгрөгийн их засварын ажлууд хийгдэж Мэс заслын тасгийн их засвар 35%, Гэмтлийн тасгийн засварын ажил бүрэн хийгдсэн.	100
47	4.1.4. Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн дэргэд граж, моргийн барилга барина.	Орон нутгийн төсөв 550,5	Гүйцэтгэлийн хувь	-	100%	Жаргалант сумын эрүүл мэндийн төвд орон нутгийн 550.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар их засвар хийгдсэн. Мөн граж, моргийн барилгын тендер зарлагдан гэрээ байгуулсан ба 2025 онд барилгын ажил хийгдэхээр төлөвлөгдсөн.	90
Зорилт 2. Санхүүгийн зарцуулалтад хяналт тавин, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллах							

48	4.2.1. Төсвийн тухай” хуулийн 8.9.2 дахь заалтын дагуу орон нутаг дахь эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн жилийн тайланг хугацаанд нь төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ. <sup>5</sup>		Хугацаандаа хүргэгдсэн тайлан	100%	100%	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд хамаарах орон нутгийн төсвийн байгууллагуудын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг төрийн аудитаар хянан баталгаажуулан Эрүүл мэндийн салбарын санхүүгийн нэгдсэн тайланг гарган Эрүүл мэндийн Сайдаас ирсэн албан хуваарийн дагуу 2024 оны 03 дугаар сарын 14-21-ны өдрүүдэд төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэл тайланд бүрэн нэгтгүүлж ажилласан. Нэгтгэл тайланд байгууллага тус бүрээр холбогдох анхан шатны баримт материалуудыг авч хадгаламжийн нэгж хэлбэрээр хүлээлгэн өгсөн.	100
49	4.2.2. Худалдан авах ажиллагааг төлөвлөх тайлагнахдаа Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалыг дагаж мөрдөх, цахим системд хуульд заасан хугацаанд оруулах, холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллана.		Хуульд заасан хугацаанд цахим системд оруулсан хувь	100%	100%	Tender.gov.mn сайтаар ажил үйлчилгээ, бараа худалдан авч ажилласан. Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 61 багцад 5,5 тэрбум төгрөгийн төсөв бүхий худалдан авах ажиллагаа зохион байгуулсан бөгөөд 1 багцын худалдан авах ажиллагаа амжилтгүй болж, 2 багцад үнийн санал авсан, 58 багцад 29 компани шалгаран гэрээ байгуулан сар тутам тогтмол, тасалдалгүй нийлүүлж ажилласан. Тайлант хугацаанд 5.28 тэрбум төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл бусад шаардлагатай барааг авч ажилласан. Мөн Ерөнхий гэрээгээр 20 компанитай 85 нэрийн эм, 6 нэрийн эмнэлгийн хэрэгслийг нийт төсөвт өртөг 1,5 тэрбум төгрөг байгаа бөгөөд одоогийн байдлаар 1,072 саяд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл авч ажилласан. Эрдэнэт медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг мөн төрийн өмчид шилжсэнээр худалдан авах ажиллагаа зохион байгуулж 42 багцын эм, эмнэлгийн хэрэгсэл, тодосгогч бодисын авах нийт төсөвт өртөг 2.1 тэрбум төгрөг, үүнээс 22 багцад тендер шалгаран гэрээ байгуулан ажилласан. Мөн ерөнхий гэрээгээр 15 компанитай 45 нэрийн эм, 6 нэрийн эмнэлгийн хэрэгслийн 233 сая төгрөгийн гэрээ байгуулснаар 218 сая төгрөгийн буюу 93,5%-тай худалдан авалт хийсэн байна. Нийт худалдан авалтын гэрээ байгуулсан компаниудын нийлүүлэлт 92,0%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,2%-аар гэрээний хэрэгжилт сайжирсан байна. Тус цахим сайтад тендерийн худалдан авах үйл ажиллагааны бүх мэдээллийг хуульд заасан хугацааны дагуу байршуулж ил тод байдлыг ханган ажилласан.	100

Стратегийн зорилго 5. Эрүүл мэндийн салбарт мэдээлэл, технологийн удирдлагыг хөгжүүлнэ.

Зорилт 1. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэн, орон нутагт хийгдэх оношилгоо эмчилгээнд алсын зайн технологи ашиглаж, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ

50	5.1.1. Алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмжийг сайжруулан, цахим эрт илрүүлэг, алсын зайн оношилгоо хийх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. <sup>2,4,5</sup>		Алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмж бүхий байгууллагын тоо	6	8	<p>Тайлант хугацаанд телемедициний хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Зүрх судасны үндэсний mn.Cardio программын цахим өвчний түүхэнд 215 хүний мэдээллийг оруулсан.</li> <li>- БНСУ-ын Бусан хотын Үндэсний их сургуулийн эмнэлгийн алсын зайн оношилгоо, эмчилгээний төв Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 2023 онд байгуулагдсан бөгөөд 2024 онд нийт 21 өвчтөнд зөвлөгөө авсан байна.</li> <li>- Жаргалант сумын эрүүл мэндийн төвд эмнэлзүйн хүнд өвчтөнд авах арга хэмжээний зөвлөмжийг БОЭТ-ийн нарийн мэргэжлийн, мэргэшсэн эмч нараас телемедицинээр авах нөхцөл бололцоо бүрдсэн.</li> <li>- Байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай, хэвтэрт байдаг иргэдийг Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хуралд телемедицинээр гэрээсээ өрхийн эмчийн хамт орон хөнгөвчлөх ажлыг зохион байгуулахаар туршилтын хурлыг зохион байгуулсан.</li> <li>- "Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийн хүрээнд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 20 ширхэг планетаар хангаж, түргэн тусламж, гэрийн эргэлт дуудлагаар очиж үзсэн эмч өвчтөний өвчний түүхийн мэдээллийг цахим системээс харах, үзлэгийн бүртгэлийг хийх, хөнгөлөлттэй эмийн жор бичих зэрэг цахим бүртгэлтэй холбоотой ажиллагааг газар дээр нь хийх боломж бүрдсэн.</li> <li>- Жаргалант сумын эрүүл мэндийн төв болон 5 өрхийн эрүүл мэндийн төвд Мобайл технологи хэрэгжиж тайлант хугацаанд мобайл технологиор гэрийн эргэлтийн IV, V-р бүлгийн эргэлт, алслагдсан багийн малчдын эргэлт, явуулын үзлэг, байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэг зэрэгт ашиглаж давхардсан тоогоор 10,000 гаруй хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.</li> </ul> <p>Тайлант хугацаанд 50 өвчтөний мэдээллийг телемедицинээр дамжуулан оношилгоо, эмчилгээний зөвлөгөө авсан байна. Алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмжийн хангалт 33.2%-тай болж өмнөх оноос 0,2%-аар нэмэгдсэн. Алсын зайн оношилгоо, телемедициний техник тоног төхөөрөмж бүхий байгууллага 11 байна.</p>	100
----	---	--	---	---	---	---	-----

51	5.1.2. Нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах үйл ажиллагаанд эрүүл мэндийн байгууллага ялангуяа хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын мэдээ мэдээллийн үнэн, зөв, шуурхай байдлыг ханган ажиллана. <sup>4</sup>		Мэдээний чанар	95,6%	95,8%	Эрүүл мэндийн статистик мэдээг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 тушаалын дагуу сар бүрийн 4-ний дотор 141 үзүүлэлтийн дагуу эрүүл мэндийн хөгжлийн төвд, 32 үзүүлэлтийн дагуу аймгийн статистикийн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна. Хувийн хэвшлийн 67 эмнэлэг үйл ажиллагаа явуулж байгаагаас ортой клиник 12, клиник 55 байна. Амарсан болон тодорхой шалтгааны улмаас ажиллахгүй эмнэлгүүд мэдээ ирүүлэхгүй шалтгааныг албан бичгээр ирүүлж, хамтран ажилласан. Хувийн хэвшлийн клиникүүдийн мэдээний ирц өмнөх оноос 0.2 хувиар нэмэгдэж 95.8 хувьд хүрсэн. ЭМХТ-ийн А/68 тоот тушаалын дагуу 2024 оны өвчлөл, эндэгдлийн цахим бүртгэл, мэдээний алдааг илрүүлж, салбар байгууллагуудад эргэн мэдээлж кодлолтын 58 алдааг засуулсан. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах Монгол улсын ерөнхийлөгчийн 2024 оны 73 дугаар зарлигийг хэрэгжүүлж орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын цахим эрүүл мэндийн системд холбуулж, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд хүн амын өвчлөл төрөлт нас баралтын мэдээг өдөр тутам мэдээлж ажилласан. Эрүүл мэндийн байгууллагын мэдээ мэдээллийн чанар 96%-тай байна.	100
52	5.1.3. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг эрүүл мэндийн байгууллагуудад үе шаттай хийлгэн гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана. <sup>5</sup>		Үнэлгээ хийлгэсэн байгууллагын тоо	-	2	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Эрүүл мэндийн газрын мэдээллийн систем, цахим хуудасны сервер, албан ажлын хэрэгцээнд төрийн байгууллагын цахим шуудангийн үйлчилгээг Үндэсний дата төвийн төв серверт байршуулан, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд орон нутгийн төсвийн 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төвд шаардлагатай сүлжээ, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр иж бүрэн Firewall сервер, сүлжээний төхөөрөмжүүд, IP камер, windows surface tablet зэрэг тоног төхөөрөмжүүдийг худалдан авч суурилуулан ашиглаж байна. Эрүүл мэндийн байгууллагуудад цахим мэдээллийн аюулгүй байдлын тухай багц хуулиудын сургалтыг эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага, мэргэжилтнүүдэд 2 удаа, эрүүл мэндийн байгууллагууд дотооддоо сургалтууд зохион байгуулж нийт давхардсан тоогоор 770 эмч, эмнэлгийн мэргэжилтэн	70



						хамрагдсан. ЦХХХЯ, ЭМЯ-аас зохион байгуулсан “Цахимд хэвшье-Digital first”, “Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд” 2 удаагийн сургалтад эрүүл мэндийн байгууллагын 800 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, эрүүл мэндийн цахим шилжилт, мэдээллийн аюулгүй байдлын талаар мэдээллээр хангагдсан. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Эрүүл мэндийн газраас Орхон аймаг дахь Тагнуулын газарт Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийлгэхээр хүсэлтээ албан бичгээр уламжилсан. Мэдээллийн нууцлал аюулгүй байдлын стандарт журмын хэрэгжилт 83%, шаардлагатай сервер, тоног төхөөрөмжийн хангалт 100% байна.	
<b>ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>							
Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж, иргэн бүрийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.							
Зорилт 1. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, олон нийтийн оролцоо, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах замаар эрүүл мэндийг дэмжих орчин бий болгох							
53	Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих “Эрүүл хамт олон” хөдөлгөөн өрнүүлж, сайн туршлагыг нийтийн хүртээл болгон урамшуулна. <sup>3,4</sup>	Орон нутгийн төсөв 6.0	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо	5	5	Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөнийг өрнүүлэн ажилласны дүнд 2024 онд 5 байгууллага шинээр Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болсон. 2024 онд ажлын байранд эрүүл мэндийг дэмжих аяны хүрээнд 3 арга хэмжээ хамтран зохион байгууллаа. Үүнд: - "Энэ жилдээ Эрүүл жиндээ-2", "Хичээллэе-Өрнүүлэе-Хөгжүүлэе" аяны хүрээнд Биеийн тамир спортын газартай хамтран "Ажлын байрны дасгал хөдөлгөөн" 2 сарын цахим уралдааныг зохион байгуулж, 33 байгууллагын давхардсан тоогоор 7384 ажилтан албан хаагчийг хамруулан, уралдаанд идэвх санаачилга гаргасан 5 байгууллагыг шагнаж урамшууллаа. - Төрийн болон төрийн бус 16 байгууллагыг хамруулсан явган алхалтад 800 хүнийг хамруулсан. - Эрдэнэт үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн албатай хамтран 33 цехийн дарга, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан 66 хүнд ажлын байранд эрүүл мэндийг дэмжих чиглэлээр сургалт зохион байгуулсан. - Төрийн байгууллага, албан хаагчдад сар бүрийн эхний 7 хоногт ажлын байр дээр эрүүл мэндээ хэрхэн хамгаалах сургалт зохион байгуулж нийт 1180 албан хаагчийг хамруулсан.	100

						- Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийг дэмжигч 86 байгууллага байгаагаас боловсролын салбарын 45, эрүүл мэндийн салбарын 14, үйлдвэр аж ахуйн нэгж 17, бусад 10 байгууллага байна. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих зорилгоор орон нутгийн төсвөөс 6.0 сая төгрөгийг шийдүүлэн ажилласан.	
Зорилт 2. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдал, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг бэхжүүлж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, салбар хоорондын оролцоо, халдварт өвчнийг хамтын ажиллагаанд тулгуурлан бууруулах.							
54	1.2.1. Заавал хийх товллын дархлаажуулалтад хүүхэд бүрийг бүрэн хамруулах, тархвар судлалын заалтаар хийх дархлаажуулалтыг зохион байгуулж, дархлаажуулалтын дараах урвал хүндрэл, тарилгатай халдварт өвчний бүртгэл, мэдээлэл, тандалтыг эрчимжүүлнэ. <sup>4</sup>		Дархлаажуулалтын хамралтын хувь	99,7	99,7%	1902 хүүхэд хамрагдаж бүрэн тунгийн хамралт 99.7 хувьтай байгаа ба хүүхдийн дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тандалт хийж, хэсэг газрын урвал 1, 37,5 хэмээс дээш халуурсан тохиолдлыг бүртгэж сар бүр ХӨСҮТ-д мэдээлж ажилласан. Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн сэжигтэй 2 тохиолдлыг мэргэжлийн багийн хурлаар хэлэлцэн дүгнэлт, зөвлөмж гаргаж, хурлаас гарсан шийдвэр, зөвлөмжийн биелэлтийг хангах чиглэлээр 3 зорилтын хүрээнд 10 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж, хэрэгжилт 90%-тай байна. 2023 онд зохион байгуулсан улаанбурхан, улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтад 16833 хамруулахаар төлөвлөснөөс 10477/62,2%/ хамрагдсан байсан ба 2024 онд 1636 хүүхдийг хамруулж, нийт хамралт 13378/79,5%/-д хүрсэн байна. УГУ нөхөн дархлаажуулалтад УГУ1 108, УГУ2 294, нийт 402 хүүхэд хамрагдсан. 2018 оноос хойш төрсөн хүүхэд 98.8%, 2016 оноос хойш төрсөн хүүхэд 93,3%, 2006-2018 онд 15000/66,6%/ хүүхдийн мэдээллийг цахимд нөхөн бүртгээд байна. Тархвар судлалын заалтаар 6 төрлийн вакцинд 9331 хүнийг хамруулсан. Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төвөөс нийт 8 удаагийн татан авалтаар 20 нэр төрлийн 58903 хүн тун вакцин, 40000 дагалдах хэрэгслийг татан авч дархлаажуулалтын тасралтгүй хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан. Халууралт тууралтат халдварын сэжигтэй 2 тохиолдлын шинжилгээг Халдварт өвчин судлалын үндэсний төвд улаанбурхан, улаануудын лабораторид хүргүүлж, онош үгүйсгэгдсэн. Гахайн хавдар өвчний 15 тохиолдлын судалгааг хийж, хариу арга хэмжээг авч ажилласан. Дархлаажуулалтын сувлагч нарт мэдлэг сэргээх, чадавхжуулах 10 удаагийн сургалтад давхардсан тоогоор 104 хүн хамрагдсан. Хүний папиллома	100

						вирусийн эсрэг вакцинд хамрагдах 11 настай 2520 хүүхдийн судалгааг гарган бэлэн байдлын хангасан. Дархлаажуулалтын цэгүүдэд 4 удаа дэмжлэгт хяналт хийн, зөвлөмж өгч ажилласан. Орон нутгаас 9,5 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн ажилласан.	
Зорилт 3. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх							
55	1.3.1. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, үед ажиллах тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж, хариу арга хэмжээний чадавхыг нэмэгдүүлнэ. <sup>4</sup>	Орон нутгийн төсөв 20,0	Хариу арга хэмжээний чадавх	95%	96%	Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 02 сарын 21-ны "Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх тухай" А/11 дүгээр тушаалаар эрүүл мэндийн салбарын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажилласан. Аймгийн Шуурхай штабын бүрэлдэхүүнд хариуцлагатай жижүүр 24 цагаар ажиллан мэдээллийг шуурхай солилцон ажилласан. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд 100% тодотгол хийгдсэн. ЭМГ-ын даргын 2024 оны А/64 дүгээр тушаалаар Тохиолдлын удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүн, ажиллах журам, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрсдэлийн харилцаа холбооны урсгалыг шинэчлэн баталсан. Тайлант хугацаанд хоолны хордлого, улаанбурхан, томуугийн хариу арга хэмжээнд тохиолдол удирдлагын тогтолцоог идэвхжүүлэн хариу арга хэмжээг авч ажилласан Химийн бодисын хордлогыг тандах мэдээлэх, химийн осол хордлогын үеийн эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг үнэлгээг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Нийгмийн эрүүл мэндийн төвөөс хийгдэж, мэдээллийн сан үүсгэсэн. Тайлант хугацаанд 1 эмийн хордлого, 6 угаарын хордлого, 1 химийн бодисын хордлогын тохиолдлыг Нийгмийн эрүүл мэндийн төвд мэдээлсэн. Тохиолдол удирдлагын тогтолцооны чадавхыг бэхжүүлэх сургалтад 5 эмч, мэргэжилтэн сургагч багшаар бэлтгэгдэн, 2 удаагийн сургалтад холбогдох байгууллагуудын 115 хүнийг хамруулан чадавхжуулсан. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавх 96.5% буюу өмнөх оноос 1,5%-аар нэмэгдсэн.	100
56	1.3.2. Гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагуудын нөөцийг нэмэгдүүлнэ. <sup>3,4</sup>		Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн	80%	85%	Тайлант хугацаанд ЭМГ-ын гамшгийн нөөцөд нэмэлтээр 1 ЭМГ-ын гамшгийн нөөцөд нэмэлтээр 1 нэр төрлийн 4,8 сая төгрөгийн эм, 5 төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж хэрэгслийн 4,6 сая төгрөгийн яаралтай тусламжийн багц, 3 нэр төрлийн 27 сая төгрөгийн хувийн хамгаалах хувцас	100

			нөөцийн хангалтын хувь			хэрэгсэл ирсэн нь өмнөх онтой харьцуулахад нөөцийн хангалт 14,27%-аар нэмэгдсэн байна. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хариу арга хэмжээнд орон нутгаас 20,0 сая зарцуулсан. Эрүүл мэндийн байгууллагууд дунджаар дунджаар 21-30 хоногийн нөөцтэй байна. Гамшгийн үеийн нөөцийн хангалт дунджаар 95.8%-тай байна.	
Зорилт 4. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн харьяалах нутаг дэвсгэрт эрүүл мэндийн чиглэлээр илэрч буй зөрчлийг арилгуулах, үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллах <sup>5</sup>							
57	1.4.1. Эрүүл мэндийн салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт хийнэ.		Объектын хамрагдалт Эрсдэлийн түвшин Хууль тогтоомжийн хэрэгжилт	100%  Их-20% Дунд-80% 83,07%	100%  Их-20% Дунд-80% 84,%	2024 оны төлөвлөгөөнд нийт 47 объектыг төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулахаар төлөвлөснөөс 100 хувь хамруулж ажилласан. Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан нийт объектын хууль сахин мөрдөлтийн хувь 80,4, эрсдэл үүсэх магадлал 22 хувьтай үнэлэгдсэн байна. Хяналт шалгалтаар нийт 495 зөрчлийг илрүүлэн, зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 479 заалттай, 42 албан шаардлага, 35 заалттай 5 зөвлөмжийг хүргүүлсэн. Албан шаардлагын хэрэгжилт 78 хувьтай хангагдсан байна.	100
58	1.4.2. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ.		Объектын хамралтын хувь, Албан шаардлагын хэрэгжилтийн хувь	100%  80%	100%  80%	Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжуудын хүрээнд нийт 288 объектод хяналт шалгалтыг хийсэн. Хяналт шалгалтаар 182 зөрчлийг илрүүлж, 85 зөрчил буюу 46,7 хувийг газар дээр нь арилгуулж, улсын байцаагчийн 88 дүгнэлт, 62 зөвлөмж, 15 албан шаардлагыг хүргүүлэн ажилласан. Албан шаардлагын хэрэгжилт 93 хувьтай байна.	100
Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангаж, орчин үеийн оношилгоо эмчилгээний дэвшилтэт технологийг өргөжүүлэх замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.							
Зорилт 1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах							
59	2.1.1. Эмнэлгүүдийг магадлан итгэмжлэлд хамруулж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.		Батлагдсан хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт	90%	90-95%	Тайлант хугацаанд магадлан итгэмжлэлд хамрагдсан 25 байгууллага байгаагаас анхан шатлалд 9 байгууллага 100%, 2 дахь шатлалд 4 байгууллага 100%, ор бүхий клиникийн 11 буюу 91,6%, клиник 1 буюу 1,8% -ийг эзэлж байна. Сум, өрхийн эрүүл мэндийн 7 төв, Шинэ эрин, Мөнхийн үйлс, Оюу ор бүхий клиник, Мишээл нөхөн үржихүйн клиник зэрэг нийт 11 байгууллага магадлан итгэмжлэлийн 36 шалгуур материалыг bakend .acc.hdc.gov.mn программаар үнэлүүлэн, 8 шинжээч дээрх байгууллагуудад ирж үнэлгээ хийснээр магадлан итгэмжлэлийн хугацааг 100% 2 жилээр сунгуулаад байна. Магадлан итгэмжлэлд хамрагдсан Эрүүл мэндийн	100

						байгууллагууд 100% чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө, магадлан итгэмжлэлийн шинжээчийн зөвлөмжийг тусган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж, хэрэгжилт дунджаар 92%-тай үнэлэгдсэн. Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, "Чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө"-ний хэрэгжилт, Эмчилгээ чанарын албад, багийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт 5 удаа, чадавхжуулах чиглэлээр сургалт мэдээлэл 6 удаа хийж, зөвлөмжөөр хангаж ажилласан.	
Зорилт 2. БОЭТ-ийн менежментийг сайжруулж, оношилгоо, эмчилгээний тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхыг нэмэгдүүлж, иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлэн шинэ дэвшилтэт технологийг нутагшуулна <sup>1</sup>							
60	2.2.1. БОЭТ-ийг санхүүжилт болон удирдлагын бие даасан хэлбэрт шилжүүлнэ.		БОЭТ-ийг санхүүжилт болон удирдлагын бие даасан хэлбэрт шилжсэн байна.	-	Бие даасан хэлбэрт шилжсэн байна.	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд 1 эмч, 1 сувилагч, 1 тусгай мэргэжилтнийг сонгон шалгаруулсан бөгөөд ЭМС-ын 2020 оны А/563 дугаар тушаалын дагуу олон нийтийн төлөөллийн мэргэжлийн нийгэмлэг 1, төрийн бус байгууллагын 1, даатгуулагчийн 1 төлөөллийг Эрүүл мэндийн яамтай хамтран сонгон шалгаруулж, 9 хүний бүрэлдэхүүнтэй болж Эрүүл мэндийн сайдын тушаалаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төлөөлөн удирдах зөвлөл байгуулагдаад байна. Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 419 оношийн хамааралтай бүлгээр сонгон шалгаруулалтад тэнцэж, ЭМДЕГ-тай гэрээ байгуулан санхүүжилт авч ажилласан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмч нарын цалинг 10,0%, эмнэлгийн тусгай мэргэжилтний цалинг 15%-аар нэмэгдүүлсэн.	100
Стратегийн зорилго 3. Эрүүл мэндийн ажилтны ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, харилцаа, хандлагыг дээшлүүлэн, нийгмийн баталгааг сайжруулна. <sup>1,2</sup>							
Зорилт 1. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн төлөвлөлт, хөгжлийг хангах							
61	3.1.1. Эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, боловсролын болон мэргэжлийн зэрэг ахиулах үйл ажиллагааг зохион байгуулна. <sup>4</sup>		Мэргэжлийн зэрэг ахиулсан эмч мэргэжилтний хувь	18,8%	20%	Тайлант хугацаанд тэргүүлэх зэргийг 13 мэргэжилтэн, ахлах зэргийг 15 эмч, эмнэлгийн мэргэжилтэн тус тус хамгаалснаар аймгийн хэмжээнд нийт зөвлөх зэрэгтэй 19, тэргүүлэх зэрэгтэй 114, ахлах зэрэгтэй 193 эмч, эмнэлгийн мэргэжилтэн байгаа нь нийт эмч, мэргэжилтний 29.5 хувь болж өмнөх оноос 2 хувиар нэмэгдсэн байна.	100
Зорилт 2. Эрүүл мэндийн ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх							
62	3.2.1. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн		Хэрэгжилтийн хувь	95,8%	96%	Эрүүл мэндийн салбарын хэмжээнд эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагын чиглэлээр нийт 39 удаагийн соён	100

	салбар хороо, хэсгийн хороодын үйл ажиллагааг тогтмолжуулж, ёс зүйн алдаа зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, алдаа, зөрчлийг бүртгэн мэдээлэх, эмнэлгийн ажилтны харилцаа хандлагыг сайжруулах ажлыг тогтмол зохион байгуулна.					гэгээрүүлэх сургалтад 1033 эмч, мэргэжилтэн хамрагдсан байна. Тус хороонд эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлагатай холбоотой 2 өргөдөл ирснийг судлан шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд эмнэлгийн мэргэжилтний харьцаа, хандлага, ёс зүйтэй холбоотой гомдол 3,5 дахин буурч, эрүүл мэндийн салбарын хэмжээнд үндсэн тусламж үйлчилгээнд иргэдийн сэтгэл ханамж 95% болж өссөн. Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 96%-тай байна.	
--	---	--	--	--	--	--	--

**ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

**Нийтлэг чиг үүрэг №1. Төрийн захиргааны удирдлага**

63	1.1. Төрийн албан хаагчдын ёс зүйг төлөвшүүлэх, эрүүл мэндийн ажилтны харилцаа хандлагыг сайжруулах сургалтыг тасралтгүй зохион байгуулна.		Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	75%	75,1%	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбоотойгоор Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/21 дүгээр тушаалаар Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хороо 5 хүний бүрэлдэхүүнтэй томилогдож, 2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан ажиллаж байна. Ёс зүйн зөрчил үүсэж болзошгүй эрсдэлд дүн шинжилгээ хийж, эрсдэлийг бууруулахаар доорх ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: - Шинээр ажилд орсон 3 албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм болон ЭМГ-ын хэмжээнд мөрдөж буй “Албан хаагчийн үйлчилгээнд тавих шаардлага CS61-0020:2015” стандартыг танилцуулан ёс зүйн алдаа дутагдал гаргахгүй ажиллах баталгааг гаргуулж авсан. - Монгол улсын ТАС-аас зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилт, 2023 оны үйл ажиллагааны тайлан хяналт” сургалтыг нийт албан хаагчдад болон Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичиг нарт зохион байгуулж, ЭМГ-ын нийт албан хаагчид 95%-тай, Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичиг 100% хамрагдсан. - Ёс зүйн чиглэлээр хийгдэж буй ажил, холбогдох эрх зүйн актууд, гарын авлага материалыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан сурталчлан ажилласан. - Аймгийн ЗДТГ-ын хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран “Үйлчилгээний ёс зүй ба ёс суртахуун” сургалтад ЭМГ-аас	70
----	--	--	---	-----	-------	---	----

						<p>30 албан хаагч, БОЭТ-өөс 50 тасгийн эрхлэгч болон ахлагч сувилагч нар хамрагдсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 12 удаагийн сургалтад давхардсан тоогоор 252 албан хаагч хамрагдсан байна.</li> </ul> <p>2024 оны байдлаар Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хороонд өргөдөл, гомдол бүртгэгдээгүй байна.</p>	
64	1.2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, чиглэлээр үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ.		Төлөвлөгөөний хэрэгжилт	98%	98%	<p>Эрүүл мэндийн байгууллагын хүрээнд 2024 онд Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 3 зорилт 8 хэрэгжүүлэх үйл ажиллагаа бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж төлөвлөгөөний хэрэгжилт 99%-тай байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- ХАСХОМ гаргалтын талаар соён гэгээрүүлэх ажлыг 43 албан хаагчийг 3 удаагийн сургалтад хамруулсан.</li> <li>- ХАСХОМ журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад ЭБАТ хариуцсан ажилтныг 2 удаа хамруулсан. Мөн тус журмын шинэчлэгдсэн заалтуудын дагуу холбогдох судалгааг аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн.</li> <li>- Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн салбарын 150 ажилтанд “Үйлчилгээний ёс зүй ба ёс суртахуун”, “Авлигын эсрэг хуулийг таниулах” сургалтыг тус тус зохион байгуулсан.</li> <li>- Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх чиглэлээр 4 төрлийн видео шторкыг эрүүл мэндийн газрын пэйж хуудсанд байршуулж 30000 гаруй хүн үзэж, 500 удаа түгээгдсэн байна.</li> </ul>	100
65	1.3. Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг бүх хэлбэрээр авч, шийдвэрлэн, шийдвэрлэлтэд хяналт тавьж, мэдээлнэ. <sup>4</sup>		Шийдвэрлэлтийн хувь	100%	100%	<p>Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой 192 санал, хүсэлт, талархал хүлээн авч хуулийн хугацаанд нь иргэдэд хүлээлт чирэгдэл үүсгэлгүйгээр 100% шийдвэрлэсэн. Үүнээс талархал 39,8%, хүсэлт 57,5%, гомдол 2.7%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад талархал 16%-аар өссөн байна. Мөн Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 11-11 төвд ирүүлсэн 8 иргэний хүсэлтийг цахимаар хүлээн авч хуулийн дагуу шийдвэрлэсэн. Өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийн мэдээлэл аймгийн ЗДТГ-ын шуурхай хурал, erdenet.mn, 70353511 дугаарт утсанд бүртгэгдэн мэдээлэгдсэн ба Эрүүл мэндийн газрын www.or.mohs.gov.mn цахим хуудаст байршуулж ил тод байдлыг ханган ажилласан. Өргөдөл, гомдлын</p>	100

						шийдвэрлэлтийн тайланг ЭМЯ болон аймгийн ЗДТГ-т хугацаанд нь хүргүүлэн ажилласан.	
66	1.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль, Шилэн дансны тухай болон Жендэрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.		Хэрэгжилтийн хувь	90,6%	90,8%	<p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 91%-тай байна.</p> <p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сургалтыг зохион байгуулж эрүүл мэндийн салбарын 100 ажилтныг хамруулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлагыг эрүүл мэндийн салбарын 500 ажилтанд түгээсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хэмжээнд гэмт хэрэг гарах, халдлагад өртөхөөс урьдчилан зорилгоор “Тэгшийн гол морьт” ХХК-тай гэрээ хийж 24 цагийн биечилсэн харуул хамгаалалтын ажилтнуудыг ажиллуулж, 72 хэсэгт хяналтын камер суурилуулан ашиглаж байгаагаас гадна талын 7, нийтийн эзэмшлийн талбайд 65, эмнэлгийн дотоод үйл ажиллагааны хяналтад зориулсан 42 IP хяналтын камер байна. Эрүүл мэндийг дэмжих төвд 8 камерыг суурилуулан ашигласан. Эрүүл мэндийг дэмжих төвд 8, Эрүүл мэндийн газарт 2 камерыг суурилуулан ашигласан. Гэмт хэрэг, болзошгүй аюулаас сэргийлэх зорилгоор шинэ жил, цагаан сарын баярын өдрүүдэд Эрүүл мэндийн газрын тушаалаар хариуцлагатай жижүүрийг томилон ажиллуулж тойрон эргэлтүүдийг хийхэд зөрчил илрээгүй байна. Эрүүл мэндийн газрын ёс зүйн зөвлөлд ажлын байран дах сахилга бат, хариуцлагын талаарх гомдол, санал ирээгүй.</p> <p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах байгууллагын нэгдсэн шилэн дансны цахим хуудсан нийт 127 мэдээлэл байршуулахаас 127 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж олон нийтэд мэдээлсэн бөгөөд хуулийн хэрэгжилт 100%-тай байна.</p> <p>Жендерийн хууль тогтоомжийн хэрэгжүүлэх хүрээнд эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулж хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд жендерийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байранд жендерийн эрх тэгш байдлыг хангах зэрэгт анхааран ажилласан. Тайлант хугацаанд гэмт хэрэг, зөрчил, ажлын байран дээрх ялгаварлан гадуурхалт, хүний эрхийг зөрчсөн асуудал бүртгэгдээгүй байна.</p> <p>Тус төлөвлөлтүүдийн хэрэгжилтийн дундаж 96,7%-тай байна</p>	100



67	1.5. Хариуцлагын тогтолцоог үйл ажиллагаандаа мөрдүүлэн албан хаагчдын цаг ашиглалт, хариуцлагыг дээшлүүлж хууль, тогтоомжийг сахин биелүүлэх, сахилга бат, хариуцлагын чиглэлээр гарсан тогтоол шийдвэрийн хүрээнд тайлангийн хугацаанд төлөвлөгөөг гарган үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн мөрдүүлэх арга хэмжээг авч ажиллана.		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	85,8	86%	Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбар байгууллагуудын шуурхай танхимаар 26, Эрүүл мэндийн газрын шуурхай танхимаар 48 удаа хуралдан, мэдээллээр ханган, үүрэг даалгавар өгч ажилласан. Эрүүл мэндийн газрын Удирдлагын зөвлөлийн хурал 7 удаа хуралдан эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлууд, ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлүүдийг хэлэлцэж, сахилга хариуцлагыг өндөржүүлж, гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан ажилласан. Тайлант хугацаанд Засгийн газрын тогтоол 2, Эрүүл мэндийн сайдын тушаал 63, аймгийн Засаг даргын захирамж 26, Эрүүл мэндийн газрын даргын А тушаал 93, Б тушаал 31 батлагдсаныг Эрүүл мэндийн газрын www.or.mohs.gov.mn цахим хуудаст байршуулж, салбар байгууллагуудад хүргүүлж сурталчлан хэрэгжилтийг ханган ажилласан. Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагууд албан хаагчдын цаг ашиглалтад хяналт тавин улирал тутам үр дүнгийн урамшуулалд нэг үзүүлэлт болгон оруулж цаг ашиглалтыг сайжруулан ажилласан. Тайлант хугацаанд төлөвлөгөөт хяналтыг Жаргалант сумын эрүүл мэндийн төв, төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй өрхийн эрүүл мэндийн төвүүд, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд тус бүр 1 удаа хийж, хяналтын дүнг ЭМГ-ын Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн зөвлөмжөөр ханган, ажлын гүйцэтгэлийг сайжруулах чиглэлээр үүрэг чиглэл өгч ажилласан. Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн хууль бусад хууль тогтоомж зөрчсөн сахилгын арга хэмжээ авагдсан тохиолдол гараагүй байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 85,94 хувьтай байна.	70
68	1.6. Байгууллагын хэмжээнд И оффис системийг бүрэн ашиглана.		Системийн ашиглалт	90%	90-100%	Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох И оффис системийг ашиглаж тайлант хугацаанд, Эрүүл мэндийн газарт шинээр орсон 4 албан хаагчид систем ашиглалтын гарын авлагыг нэг бүрчлэн хүргүүлж ашиглалтыг хянах ажлыг зохион байгуулсан. Тус программаар нийт 395 албан бичиг хүлээн авч 462 бичиг хүргүүлж, иргэдээс 192 санал хүсэлт, талархал хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. И оффис системийн ашиглалт 100% байна.	100
Нийтлэг чиг үүрэг №2. Хэвлэл мэдээлэл							

69	2.1. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах		Мэдээлэл сурвалжилгын тоо	107	108	Эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар 2 удаагийн хэвлэлийн бага хурал, 40 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизэд, 5 удаагийн мэдээллийг FM радиогоор хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн..	70
70	2.2. Аймаг, орон нутгийн батлан хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, дэд хөтөлбөрүүдийг иргэд олон нийтэд хүргэх, зохион байгуулж буй үйл ажиллагааг иргэд олон сурталчилна. <sup>4</sup>		Сурталчилсан тоо	15	20	<ul style="list-style-type: none"> <li>- Аймгийн хэмжээнд хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүд болон байгууллагын зохион байгуулсан ажлын мэдээ мэдээллийг цаг тухай бүр иргэд олон нийт, эрүүл салбарын нийт ажилтнуудад хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран түгээсэн. Байгууллагын цахим хуудсаар дамжуулан 213 зурган болон видео шторк бэлтгэн хүргэсэн ба давхардсан тоогоор 786500 иргэнийг мэдээ мэдээллээр хангаж ажилласан.</li> <li>- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулсан Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудлыг дэмжих “Эмч” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдсэн үйл ажиллагаануудыг цахим хуудсанд нийтэлж олон нийтэд түгээж ажилласан.</li> <li>- 40 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизээр, 150 гарын авлага, 51 урилга, 45 эх бэлтгэл, иргэдийг мэдээллээр ханган ажилласан.</li> <li>- Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 494 дүгээр тушаал болон эрүүл мэндийн салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, тусламж үйлчилгээг сурталчлах, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор нээлттэй хаалганы өдөрлөг 1 удаа, “Эрдэнэт-Үйлдвэр” ТӨҮГ-н FM радиогоор үйлдвэрийн нийт албан хаагчдад 5 удаагийн шууд нэвтрүүлэг, “Эрүүл мэндийн үйлчилгээг иргэн бүрд” 20 удаагийн цуврал контент видеог facebook/reel/, ORKHON_EMG инстаграм хаяг, youtube сувгаар дамжуулан иргэдэд сурталчилсан.</li> </ul>	70
Нийтлэг чиг үүрэг №3. Төсөв, санхүү, эдийн засаг							
72	3.2. Өмч хөрөнгийн бүртгэл, тооллого, хөдөлгөөн, ашиглалт хамгаалалт, эзэмшигчийн хариуцлагыг дээшлүүлэх ажлыг байгууллагуудын		Арга хэмжээний тоо	2	2	Эрүүл мэндийн газрын Өмч хамгаалах байнгын зөвлөл нь 2024 оны ажлын төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилт 95%-тай байна. Тус зөвлөл 4 удаа хуралдаж, эхний хагас жилийн болон жилийн эцсийн өмч хөрөнгийн тооллогын зохион байгуулж, байгууллагын Удирдлагын зөвлөлийн хуралд тайлагнасан. Эрүүл мэндийн газрын үндсэн хөрөнгийн	100

	хэмжээнд сайжруулах арга хэмжээг авч ажиллана.					дансанд бүртгэлтэй 1 портер машиныг Бүсийн оношилгоо эмчилгээний төвд шилжүүлж өгсөн. Мөнхсүндрэл, Энхжихмандариваа, Нийцэл өрхийн эрүүл мэндийн төвүүдийн барилга байгууламж, халаалт цэвэр бохир усны дэд станцууд, нийтийн эзэмшлийн эд хогшлыг Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгсөн. 19 нэр төрлийн аж, ахуйн эд хогшил, 18 нэр төрлийн машин тоног төхөөрөмж нийт 37 нэр төрлийн эд хөрөнгийг актлуулах саналыг Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.	
Нийтлэг чиг үүрэг №4. Тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээ							
73	4.1. Монгол улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2024 оны улсын болон аймгийн жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлж тайлагнана.		Хэрэгжилтийн хувь	90%-94%	92-94%	Эрүүл мэндийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хугацаанд нь тайланг Эрүүл мэндийн яам болон аймгийн Засаг даргын тамгын газарт албан тоотоор хүргүүлэн ажилласан. Үүнд: - Монгол улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 2 зорилтын хүрээнд 27 арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж ажилласан ба хэрэгжилт дунджаар 91.1%-тай /тодорхой үр дүнд хүрсэн/ - Монгол улсын Их хурлын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд туссан эрүүл мэндийн салбарт хамаарах 6 арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж ажилласан ба хэрэгжилт дунджаар 98,3%-тай /тодорхой үр дүнд хүрсэн/ - Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 97,4%-тай /тодорхой үр дүнд хүрсэн/ - Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт 97,85% (тодорхой үр дүнд хүрсэн) тус тус үнэлэгдсэн байна. Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт дунджаар 96.2 хувьтай байна.	100
74	4.2. Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг		Хэрэгжилтийн хувь	92,5%	92,8%	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу Эрүүл мэндийн газраас нэгтгэгдэн гарч буй хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон бодлогын баримт бичгийн 2024 оны	100

	ханган ажиллаж, тогтоосон хугацаанд тайлагнана.					хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх явцад албан хаагчдыг зөвлөмжөөр ханган тайланд тухай бүр сайжруулалт хийж, зөвлөмж, илтгэх хуудсыг албан хаагчдад хүргүүлэн ажилласан. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд хэрэгжиж буй эрүүл мэндийн салбарт хамааралтай Монгол улсын хууль 1, УИХ-ын тогтоол 2, УИХ-ын Байнгын хорооны тогтоол 4, Засгийн газрын тогтоол 6, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 3, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол 4 хяналтад авч, хэрэгжилтийг ханган тогтоосон хугацаанд тайлагнаж ажилласан. Хэрэгжилт дунджаар 94 хувьтай өмнөх оноос 1,5%-аар нэмэгдсэн байна.	
75	4.3. Байгууллагад хийгдэх дотоод хяналтыг удирдан зохион байгуулж, төлөвлөгөөний дагуу хяналт хийж, зөвлөмж өгнө.		Дотоод хяналт хийгдсэн тоо	10	10	Байгууллагын Дотоод хяналтын багийг шинэчлэн байгуулах тухай Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/412 дугаар тушаалыг батлуулсан. Дотоод хяналтын багийн 2024 оны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажилласан. Эрүүл мэндийн газрын дотоод хяналтын багаас 2023 онд хийгдсэн төлөвлөгөөт хяналтын дагуу өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг нэгтгэж дүгнэхэд хэрэгжилт 91,9%-тай үнэлэгдсэн. Эрүүл мэндийн байгууллагуудын дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр 2 удаагийн сургалт хийж 42 эмч, мэргэжилтнийг хамруулж, БОЭТ-ийн 22 тасаг нэгжийн дотоод хяналтын баг бүрэлдэхүүнийг ажлын байранд арга зүйгээр хангасан. Тайлант хугацаанд төлөвлөгөөт хяналт 8, төлөвлөгөөт бус 2 хийгдэж, зөвлөмжөөр ханган ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 94%-тай байна.	100
<b>ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ</b>							
Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж, иргэн бүрийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.							
Зорилт 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах							
76	Засгийн газрын 2023 оны 321 дүгээр тогтоолоор батлагдсан “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх” арга хэмжээг бусад салбар нэгжийн оролцоог ханган зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллана. <sup>5</sup>		Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-	85%	Тайлант хугацаанд 26 удаагийн өдөрлөг, аян, форум, 235 удаагийн сургалт сурталчилгаанд давхардсан тоогоор 37499 иргэнийг хамруулж, 55 төрлийн сурталчилгааны материалыг 9471 иргэнд түгээсэн. Боловсролын газартай хамтран 27 ерөнхий боловсролын сургуулийн 1-12 ангийн 1256 бүлгийн багшид сургалт зохион байгуулж 25866 суралцагчид түгээх ажлыг зохион байгуулсан. Сургуулийн өмнөх боловсролын 32 цэцэрлэгийн арга зүйч болон эмчид хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр 5 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 64 хүнийг хамруулсан.	90

						<p>Эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар 2 удаагийн хэвлэлийн бага хурал, 40 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизэд, 5 удаагийн мэдээллийг FM радиогоор хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн.</p> <p>Нийгмийн эрүүл мэндийн хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгаас 26.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдүүлж үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаж байна.</p> <p>“Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх” арга хэмжээний хэрэгжилт 83 хувьтай байна.</p>	
77	1.1.2. Нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр нийтийг хамарсан арга хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг өргөнөөр татан оролцуулах арга хэмжээг зохион байгуулна. <sup>5</sup>		Зохион байгуулсан арга хэмжээний тоо	3	4	<p>Тайлант хугацаанд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр 15 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээнд 56 аж ахуйн нэгж, байгууллага, 38605 иргэнийг хамрууллаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил-2024" өдөрлөгөөр давхардсан тоогоор 765 иргэнд үзлэг хийж, 35 төрлийн гарын авлага зөвлөмжийг 1530 иргэнд түгээн, 4 төрлийн тэмцээнд 70 иргэнийг хамруулсан.</li> <li>- Иргэд олон нийтийг эрүүл мэндийн сургагч багшаар бэлтгэх сургалтад улаан загалмай болон хүүхдийн зөвлөлийн сурагчид, багийн идэвхтэн, оюутан нийт 140 иргэнийг эрүүл мэндийн сургагч багшаар бэлтгэсэн.</li> <li>- “Эрдэнэт” сувилал, "Монос фарм трейд", “Нью верамед” ХХК, хувийн хэвшлийн “Катарсис” клиниктэй хамтран “Би өөртөө хайртай” өдөрлөгт “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2500 ажилтныг хамруулж, сургалт болон нойргүйдлийн богино сорилд хамруулж зөвлөгөө өгч ажилласан.</li> <li>- Дэлхийн гэр бүлийн өдрөөр соён гэгээрүүлэх, нөлөөллийн арга хэмжээнд 12 аж ахуйн нэгж байгууллагын 4500 иргэн хамрагдсан.</li> <li>- Амны хөндийн эрүүл мэнд, гарын ариун цэвэр, хүүхдийн хоол тэжээл зэрэг чиглэлээр нөлөөллийн арга хэмжээнд 200 хүнийг хамруулсан.</li> <li>- Оюутныг дэмжих сарын аяны хүрээнд Эрдэнэт цогцолбор дээд сургууль, Политехник коллежийн нийт 700 гаруй оюутанд эрүүл мэндийн боловсрол олгох өртөөчилсэн сургалт зохион байгуулсан.</li> </ul>	100

						- “Эрүүл Эрдэнэт хүн” төслийн хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн зорилтот бүлгийн иргэдийг хавдрын эрт илрүүлэг үзлэгт 5000 хүн, 6,17 настай 4100 хүүхэд буюу 93,8%-тай зүрхний цахилгаан бичлэгт, нийгмийн эрүүл мэндийн нөлөөллийн арга хэмжээнд 30000 гаруй иргэний хамруулсан.	
78	1.1.3. Нийгмийн халамж нэн шаардлагатай жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг аминдэмд хамруулна. <sup>3</sup>	Орон нутгийн төсөв 10.0	Аминдэмжүүлэлтийн хангалтын хувь	15%	17%	Нийгмийн халамж нэн шаардлагатай бүлгийн жирэмсэн болон хөхүүл эхийг аминдэмээр хангах зорилгоор аймгийн Засаг даргын 2024 оны А/472 дугаар захирамжаар батлагдсан 10.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн эмчилгээний зорилгоор 243, урьдчилан сэргийлэх тунгаар 644, нийт 887 жирэмсэн болон хөхүүл эхийг аминдэмд хамруулсан. Аминдэмд хамрагдсан нийт 887 эхээс 243 буюу 27,4 хувь нь цус багадалттай эх байгаа ба эх барихын хүндрэлгүй төрүүлсэн. Тайлант хугацаанд аминдэмд хамрагдах эхийн тоо өмнөх онтой харьцуулахад 1.2 дахин нэмэгдсэн.	100
79	1.1.4. Хорт хавдартай иргэдийн эмийн болон эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлнэ. <sup>3</sup>	Орон нутгийн төсөв 100.0	Дэмжлэгт хамрагдсан хорт хавдартай иргэдийн хувь	69,2%	69,5%	Хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр орон нутгийн төсвөөс 2021 онд 128 иргэнд 60.0 сая төгрөг, 2022 онд 177 иргэнд 69.8 сая төгрөг, 2023 онд 162 иргэнд 69.8 сая төгрөгийг тус тус олгосон байна. 2024 онд хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр орон нутгийн төсөвт 100.0 сая төгрөгийг баталснаас одоогийн байдлаар 154 иргэнд 84.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн ба шинээр батлагдсан тохиолдлын 80.2 хувь нь эмийн болон эмчилгээний дэмжлэгт хамрагдсан байна	100
Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангаж, орчин үеийн оношилгоо эмчилгээний дэвшилтэт технологийг өргөжүүлэх замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.							
Зорилт 1. Эмнэлгийн яаралтай тусламжийн төвлөрлийг сааруулах, иргэдэд үзүүлэх яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх.							
80	2.1.1. Яаралтай тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад нэгж байгуулах, амь тэнссэн тусламж үйлчилгээг үзүүлэх чадавхыг нэмэгдүүлнэ. <sup>3</sup>		Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний чадавх	90%	91%	ЭМС-ын 2021 оны А/814 дүгээр тушаалын дагуу яаралтай тусламжийн багаж тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгслийн хангалт 95%-д хүрч өмнөх оны мөн үеэс 4 хувиар нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн чанар хүртээмж, багаж тоног төхөөрөмжийн хангалтад 2 удаа дэмжлэгт хяналт хийж зөвлөмж өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Тайлант хугацаанд яаралтай тусламжийн хүлээн авах тасгаар 21687 үйлчлүүлж, 8,4% нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн ба 72 цагийн дотор давтан үзүүлсэн тохиолдол 354 буюу 1,6% байна. Нийт үйлчлүүлэгчийн 2884	100

						<p>6/8,4%/ нь харьяаллын бус үйлчлүүлэгч байна. Яаралтай тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв нь 100% яаралтай тусламж үзүүлэх нэгжийг байгуулан нэн шаардлагатай багаж тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгслийн хангалт 95,8%-тай байна.</p> <p>Хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төгсөлтийн дараах сургалтад 2023-2024 оны хичээлийн жилд “Яаралтай тусламжийн сувилахуй”-аар 2, “Эрчимт эмчилгээний сувилахуй”-аар 2 эмнэлгийн мэргэжилтэн суралцаж байна.</li> <li>- Хувийн хэвшлийн 7 ор бүхий клиник яаралтай тусламжийн мэргэшсэн сувилагчийг ажиллуулж байна.</li> <li>- Яаралтай, амилуулах суурь тусламж үзүүлэхэд эмч нарын ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Би эмч” ажил мэргэжлийн уралдаанд анхан болон 2 дахь шатлал, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын 36 эмч, эм зүйч нар оролцон ур чадвараа нэмэгдүүлсэн.</li> <li>- “Хойд бүс нутгийн эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, хөх кодоор ажиллах чадварт суралцах нь” бүсийн сургалтад 150, амь тэнссэн үеийн дотоодын сургалтад 48 нийт 198 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан.</li> </ul> <p>Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний чадавх 91,5%-тай байна.</p>	
81	2.1.2. Түргэн тусламжийн төв, салбаруудын үйл ажиллагааг жигдрүүлэх, түргэн тусламжийн үйлчилгээг шуурхай үзүүлнэ.	Улсын төсөв 540.3  Орон нутгийн төсөв 385,0	Түргэн тусламжийн төвийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ, Нэн яаралтай дуудлагад 20 минутын дотор очсон хувь	100%	100%	<p>Аймгийн хэмжээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн түргэн тусламжийн тасагт туулах чадвар сайтай, бүрэн тоноглогдсон 7, хагас тоноглогдсон 4 нийт 11 машин яаралтай тусламжийн дуудлагад үйлчилж ажилласан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 540.3 сая төгрөгийн түргэн тусламжийн бүрэн тоноглогдсон автомашинаар хангагдсан.</p> <p>Түргэн тусламжийн үйл ажиллагааны зардалд орон нутгаас 285 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Түргэн тусламжийн үйл ажиллагаанд 1 удаа хяналт хийж, зөвлөмжөөр ханган ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд 14716 иргэн түргэн тусламжийн үйлчилгээ авснаас нэн яаралтай дуудлагад 20 минутын дотор очсон хувь 100% байна.</p>	100

Зорилт 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах

82	2.2.1. Эрүүл мэндийн байгууллагыг цахилгааны тасралтгүй эх үүсвэрээр хангах, цахилгаан эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдэлээс сэргийлж дотоод хяналтыг тогтмолжуулж, цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдлыг ханган ажиллана. <sup>5</sup>		Нөөц эх үүсвэрийн бэлэн байдлын хувь	90%	91%	Цахилгаан эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдэлээс сэргийлэх хүрээнд: - Бүсийн оношилгоо эмчилгээний төв 110 кватт-ын чадалтай 2 нөөц цахилгаан үүсгүүртэй бөгөөд 3 блокийн 13 тасаг нэгжийг аваарын үед цахилгаан тэжээлээр ханган ажилласан. Тайлант хугацаанд 12 удаа цахилгаан тэжээл тасарсан үед нөөц цахилгаан үүсгэвэр нийт 234 минут ажилласан байна. - Мэргэжлийн байгууллагаар 4 удаа шалгалт тохируулга хийлгэж, 3 удаа ажиллагааны шалгалт хийсэн. - Ажлын байран дахь аюулгүй ажиллагааны чиглэлээр тасаг нэгжийн 42 ажилтныг хамруулан сургалт зохион байгуулсан. - Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах чиглэлээр хагалгаа, мэс заслын тоног төхөөрөмжүүдийг өдөр бүр шалгалт тохируулга хийж тэмдэглэл хөтөлсөн. - Эрсдэлээс сэргийлэх чиглэлээр өвчтөнүүдийн байнга харьцаж болох цахилгаан хэрэгслүүдэд өдөр тутмын хяналт хийж ажилласан. - Эрдэнэт медиал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлгүүд 110 кВ цахилгааны эх үүсгэвэртэй, цахилгаан саатлын үед 24-48 цаг ажиллах боломжтой ба шатахуунаар цэнэглэн хэвийн ажиллах хүчин боломж бүрдсэн. - Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 10 цахилгааны эх үүсгэвэр байна. Нөөц эх үүсвэрийн бэлэн байдал 91,5%-тай болж, өмнөх оноос 1,5%-аар нэмэгдсэн байна	100
Стратегийн зорилго 6. Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага зохион байгуулалт ил тод байдлыг ханган ажиллах							
Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага зохион байгуулалтын чиглэлээр							
83	6.1.1. Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын дагуу Эрүүл мэндийн газрын дунд хугацааны бодлогын баримт бичиг болох стратеги төлөвлөгөөг		Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	90,5%	Эрүүл мэндийн газрын 2021-2024 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 60 үйл ажиллагааг төлөвлөсөн бөгөөд тус төлөвлөгөөний 2021-2024 оны хэрэгжилтийг нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд, хэрэгжилт 91,2% байгаа бөгөөд Эрүүл мэндийн яаманд тайланг хүргүүлсэн. Эрүүл мэндийн байгууллагуудын дунд хугацааны бодлогын баримт бичиг Стратеги төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг	100



	шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана. <sup>5</sup>					хангах чиглэлээр 2 удаагийн мэдээллийг удирдлагуудад өгч, 1 удаагийн дэмжлэгт хяналт хийж, зөвлөмжөөр хангасан. ЭМГ-ын 2025-2029 онд хэрэгжүүлэх шинэ стратеги төлөвлөгөөг батлуулах бэлтгэл ажлын хүрээнд ЭМГ-ын даргын А/89 дүгээр тушаалаар стратеги төлөвлөгөөг батлуулах ажлын хэсгийн 7 хүний бүрэлдэхүүнтэй томилсон бөгөөд орчны, мандатын шинжилгээнүүд хийгдэж байна. Эмч мэргэжилтнийг чадавхжуулах хүрээнд ЭМГ-ын 3 ахлах мэргэжилтэн Удирдлагын академиас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулах сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан. Мөн тус академиас зохион байгуулсан байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулах, Pestel аргыг ашиглах чиглэлээр зайн сургалтад эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага 12 хүн хамрагдсан.	
2. Төрийн үйлчилгээний ил тод байдлыг ханган, төрийн үйлчилгээг сайжруулах							
84	6.2.1. Чанарын ISO 9001-2015 стандартыг эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлнэ.		Чанарын ISO 9001-2015 стандарт нэвтэрсэн байгууллагын тоо	4	2	Тайлант хугацаанд: <ul style="list-style-type: none"> <li>- Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартыг хувийн хэвшлийн 1 ортой гэрчилгээ авч, нэг клиник, 1 өрхийн эрүүл мэндийн төв баталгаажуулах шатанд байна.</li> <li>- Чанарын менежментийн тогтолцооны дотоод аудитор бэлтгэх сургалтад 13 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж гэрчилгээг гардан авсан.</li> <li>- Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих стандарт MNS 7014:2023, Эрсдэлийн менежментийн тогтолцоо ISO 31000:2020-ны 5 удаагийн сургалтад 270 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бүсийн форумд 12 удирдах ажилтан, эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан</li> <li>- Эрүүл мэндийн салбарын хэмжээнд Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэх сайн дурын НICO клубийг шинээр нээж 2 удаагийн уулзалтыг зохион байгуулсан.</li> </ul> Аймгийн хэмжээнд 4 эрүүл мэндийн байгууллага Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартыг нэвтрүүлсэн бөгөөд 3 байгууллага баталгаажуулах шатанд байна.	100
85	6.2.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг		Нэвтрүүлсэн сайн туршлага	5	5	Тайлант хугацаанд эрүүл мэндийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 8 төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж буй үйл ажиллагааны чиглэл болон үйл	100

	сайжруулахад иргэн, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж Нийгмийн эгэх хариуцлагын сайн туршлагыг нэвтрүүлэн ажиллана. <sup>5</sup>					ажиллагааг мэдээллийн самбар болон цахим хуудсаар сурталчлан, дэмжин хамтран ажилласан. Тухайлбал: <ul style="list-style-type: none"> <li>- Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгийн сайн дурын 2 идэвхтэнтэй хамтарч сүрьеэ өвчнөөр эмчлэгдэж байгаа 6 иргэний эмийг хяналттай уулгасан. Мөн тус нийгэмлэгээс зорилтот бүлгийн 6 иргэнд аминдэм болон хүнсний тусламж олгосон байна. Эмзэг бүлгийн сүрьеэтэй иргэдийн нийгмийн халамж дэмжлэгт хамрагдсан хувь 17,1% байна.</li> <li>- Аймгийн явган алхалтын холбоотой хамтран “Энэ жилдээ эрүүл жиндээ” явган алхалтыг 4 удаа зохион байгуулж 2000 гаруй хүн хамруулж, “Орхон 100 км” улсын хэмжээний алхалтад хамрагдах 200 иргэнд эрүүл мэндийн байгууллагаас 5 сая төгрөгийн үнэ бүхий аминдэмийн багцаар дэмжлэг үзүүлсэн.</li> <li>- Архидалт мансуурлын эсрэг ассоциацийн архинаас татгалзах сэдэл төрүүлэх, сайн туршлага хуваалцах нөлөөллийн ажилд давхардсан тоогоор 925 иргэн хамрагдсан.</li> <li>- Аймгийн Ахмадын хороотой хамтран настны эрүүл мэндийг дэмжих чиглэлээр “Үүргэвчтэй аялал”, “Эрүүл мэнд. Эко гороо аялал”, ахмадуудын дунд спортын 3 төрөлт тэмцээн зэргийг зохион байгуулж 500 гаруй ахмадыг хамруулсан байна.</li> <li>- “Ариун саруул бат”, “Сэтгэлзүйн цогц боловсролын төв” зэрэг 2 төрийн бус байгууллагатай хамтран 2 үйл ажиллагаа зохион байгуулж 3000 гаруй хүнд сургалт болон сэтгэлзүйн зөвлөгөө өгч ажиллалаа.</li> <li>- “Харилцааны гайхамшиг” төрийн бус байгууллагатай хамтран сургалт, уулзалт 4 удаа зохион байгуулж 160 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.</li> <li>- Монголын шүдний ерөнхий эмч нарын холбоотой хамтран “Шүд угаалтын аварга шалгаруулах” тэмцээнд 24 сургуулийн 192 сурагч, 152 багшийг хамруулсан.</li> </ul>	
86	6.2.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлэх, сурталчлах,		Хэрэгжилтийн хувь	-	80%	Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартын хэрэгжилтийг нэмэгдүүлэх чиглэлээр “Эрүүл Мэндийн Үйлчилгээг Иргэн бүрт” аяныг өрнүүлэн чиглүүлэх сургалтыг 4 удаа, эрүүл мэндийн цагаан толгой цуврал контент 20 хийж, иргэдийг мэдээллээр хангасан. Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/18 дугаарт удирдамжийн дагуу 26 эрүүл мэндийн байгууллагад	70

	хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. <sup>5</sup>					<p>106 заалтын дагуу үнэлгээ хийхэд MNS 7014:2023 Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага стандартын хэрэгжилт 79.6%-тай байна. Үүний дагуу 26 албан шаардлага, 3 зөвлөмжийг хүргүүлж хэрэгжилтийг нэмэгдүүлж ажилласан. Стандартын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Стандартын чиглүүлэх сургалтыг 2 сургагч багш 7 удаа зохион байгуулж, 198 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.</li> <li>- Бүсийн оношилгоо, эмчилгээний төв нь дотоодын сургалтад 26 тасгийн 282 эмч, сувилагчийг хамруулсан.</li> <li>- Эрүүл мэндийн цагаан толгой цуврал контентын 20 бичлэгийг Эрүүл мэндийн газрын цахим хуудаст байршуулж тайлант хугацаанд нийт 27198 үзэлттэй байна.</li> <li>- Аяны хүрээнд эрүүл мэндийн анхан шатны байгууллагаар үйлчлүүлэгсдийн сэтгэл ханамжийн судалгааг SERVQUAL асуумжаар 392 иргэнээс авч үр дүнг боловсруулан, сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг сайжруулах чиглэлээр зөвлөмж хүргүүлсэн.</li> <li>- Этүгэн их сургуультай хамтран “Эмнэлгийн ажилтнуудын дүр төрх, үйлчилгээний соёл” сэдвээр сургалт зохион байгуулж, 12 байгууллагын 60 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамрууллаа.</li> </ul>	
87	6.2.4. Байгууллагын хэмжээнд иргэд, олон нийтэд хүрсэн шинэлэг ажлыг зохион байгуулж үр дүнг мэдээлнэ.		Зохион байгуулсан шинэлэг ажлын тоо	4	4	<p>Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын хэмжээнд иргэд олон нийтэд хүрсэн шинэлэг 5 ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 3939 хүнийг хамруулсан Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Эмч” хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр ажил мэргэжлийн ур чадварын 3 уралдааныг зохион байгуулж 22 багийн 104 эмч, сувилагчийг хамруулж 9 байрыг шалгаруулж урамшуулсан.</li> <li>- Цагаан тоосны бүсэд амьдарч байгаа нөлөөллийн бүсийн болон нөлөөллийн бус бүсийн 2005 иргэнийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.</li> <li>- Орхон аймгийн Баян-Өндөр сумын 30 жилийн ой, “Энэ жилдээ-Эрүүл жиндээ-2” аяны хүрээнд “Бүх нийтийн явган алхалт”-ыг эрүүл мэндийн салбарын 300 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан албан хаагч, иргэд олон нийтийг хамруулан зохион байгуулсан.</li> <li>- “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил-2024” нээлттэй хаалганы өдөрлөгт 17 эрүүл мэндийн байгууллага 765 иргэнд үзлэг хийж, үйл ажиллагааг сурталчлан, 35 төрлийн</li> </ul>	100

						<p>гарын авлага зөвлөмжийг давхардсан тоогоор 1530 иргэнд түгээсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Эрүүл мэндийн үйлчилгээг иргэн бүрд” аяны хүрээнд Эрүүл мэндийн цагаан толгой цуврал контент 20 дугаар бэлтгэж, Эрүүл мэндийн газрын цахим хуудсаар дамжуулан 329100 иргэнд хүргэж ажилласан.</li> </ul>	
88	6.2.5. Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг ил тод цахимжуулах, хөнгөн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулна. <sup>4</sup>		Цахимжуулсан үйлчилгээний тоо	2	1-2	<p>Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг erdenet.mn, or.mohs.gov.mn, Орхон аймгийн Эрүүл мэндийн газар цахим хуудас, олон нийтийн сүлжээнд мэдээ мэдээллийг байршуулан, иргэдэд түгээсэн. Цахимаар иргэдэд хүргэж буй үйлчилгээ:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газар, ЭМЯ-наас E-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн системийн хөгжүүлэлтийг нэгдсэн журмаар зохион байгуулж байгаа бөгөөд тус "E-Mongolia" системээс эрүүл мэндийн 19 төрлийн үйлчилгээг иргэд авч байна. Тайлант хугацаанд эрүүл мэндийн эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр, эмийн жор бичилт зэрэг 7 үйлчилгээг "E-Mongolia" системээс авах боломжтой болсон.</li> <li>- Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй “Цахим Эрдэнэт-1” төслийн хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн төвийн гэрийн дуудлага, гэрийн эргэлт болон Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн түргэн тусламжийн дуудлагын үед цахим программд үзлэгийн бүртгэл хөтлөх ажиллагааг хялбаршуулах, хөнгөлөлттэй эмийн жорыг тухайн газарт нь бичиж, кодыг олгох зориулалтаар ашиглах зөөврийн таблет ашиглаж байна.</li> <li>- Хувийн хэвшлийн клиникүүдийн статистик мэдээг google формат ашиглан цахимаар авч байгаа нь мэдээний ирцийг нэмэгдүүлсэн.</li> </ul>	70
89	6.2.6. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	95%	96%	<p>Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны А/92 тоот тушаалаар Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүн тайлант хугацаанд 3 удаа хуралдаж албан хаагчдын 2023 оны хадгаламжийн нэгжүүдийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу тулган, баримтын үнэ цэнийг нягтлан шалгаж нийтлэг зөрчлийг арилгуулан 145 хадгаламжийн нэгжийг архивт хуулийн хугацаанд хүлээн авсан. “Байгууллагын архивын үндсэн заавар”, “Архив албан хэрэг хөтлөлтийн журам”-ыг ЭМГ-ын даргын А/18 дугаар тушаалаар батлуулж, албан хаагчид журам заавар стандартын хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажилласан. Үүнд:</p>	83,3

						<ul style="list-style-type: none"> <li>- Улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөг батлуулж, Улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулан даргын тушаалаар баталгаажуулсан.</li> <li>- Архив, албан хэрэг хөтлөлтийн эрх зүйн баримт бичгийн талаар танилцуулга хийж, 2018-2023 оны байгууллагад үүсэж хөтлөгдсөн архивын баримтыг эмхлэн цэгцэлж байгууллагын архивт хүлээн авч, баримт бичгийн эмх цэгц, бүрдэл, хадгалалт, хамгаалалтыг сайжруулсан.</li> <li>- Тус байгууллагын архивын зориулалтын өрөө бүхий, өрөөнд шаардагдах техник хэрэгсэл /зориулалтын тавиур, 2 нягтруулсан шүүгээ, галын дохиолол, чийгшүүлэгч зэрэг/-ийг байршуулж хадгалалт, хамгаалалтад тавигдах шаардлагыг зохих түвшинд хангаж ажилласан.</li> <li>- Албан хэрэг хөтлөлтийн стандартын чиглэлээр салбар байгууллагын 48 ажилтанд сургалтыг зохион байгуулсан.</li> <li>- Аймгийн төрийн архивт баримтын бүртгэл тоо хэмжээ хадгалалтын талаарх нэгдсэн мэдээг хугацаанд нь хүргүүлсэн бөгөөд үндсэн хөрөнгийн баримт болох устгах болон шилжүүлэх 1172 хадгаламжийн нэгжийг Төрийн архивт хүлээлгэн өгсөн.</li> <li>- www.eoffice.erdnet.mn сайтад байгууллагын архивт хадгалагдаж буй хадгаламжийн нэгжийн холбогдох мэдээллийг 100% нөхөн оруулсан.</li> <li>- Архивын лавлагаа авах 14 хүсэлтийг шийдвэрлэж архивын баримтаас хуулбар лавлагааг журмын дагуу шийдвэрлэсэн.</li> </ul> <p>Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувьтай байна.</p>	
Хэрэгжилтийн дундаж хувь 95,4%							

Төлөвлөгөөг хянасан:

Аймгийн Засаг дарга  
(албан тушаал)

Тэмдэг

.....  
(гарын үсэг)

/Б.Зоригтбаяр/

(огноо)

.....

Төлөвлөгөө тайлагнасан:

Эрүүл мэндийн газрын дарга .....

(албан тушаал)

(гарын үсэг)

/Ц.Мөнхцэцэг/

(огноо)

Тэмдэг

.....